



Бүдээгийн БАЯРЧИМЭГ



АМИН ХЭЛХЭЭ



ӨМНӨГОВИЙН СУРГАМЖИТ ӨГҮҮЛЛЭГҮҮД

2013 он

*Эх орон минь, эх байгаль минь чамайг
үеийн үед үүрд хамгаална!*

Бүдээгийн БАЯРЧИМЭГ

АМИН ХЭЛХЭЭ



ӨМНӨГОВИЙН СУРГАМЖИТ ӨГҮҮЛЛЭГҮҮД

Бодит үйл явдлаас сэдэвлэн бичив.

Өмнөговь аймаг

2013 он

DDC
808.803 7
Б-381

Зохиогч: Бүдээгийн БАЯРЧИМЭГ

Редактор: Цэдэвдамбын Оюунчимэг

Дизайнер: Сосорбарамын Лхагвасүрэн

Чимэг зургийг: Батсүхийн Ганзориг

Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн: Талантбүүк ХХК
Утас: 70104458

“Тэнүүн принтинг” эхийг бэлтгэж хэвлэв.
Утас: 96661007, 99194715

ISBN 978-99973-839-3-8

© Copyright Bayarchimeg Budee

ӨМНӨХ ҮГ

Залуу зохиогч Бүдээгийн Баярчимэгийн анхны бүтээл болох “Амин хэлхээ” сургамжит өгүүллэгийн номыг уншигч Таны гэгээн мэлмийд толилуулж байна.

Монгол ахуйн өдөр тутмын амьдралд тохиолдох адал явдлуудаар дамжуулан байгаль дэлхийгээ хайрлах монголчуудын сэтгэлгээг өвөрмөцөөр илэрхийлж, эх байгальтайгаа зохицож амьдрах ухааныг ойлгуулсан энэхүү бүтээл нь “Дусал ус”, “Амь аварсан хоточ”, “Моддын дуу” хэмээх гурван бүлэг, 21 өгүүллэгээс бүрджээ. Зохиогч бүтээлдээ төрж өссөн говь нутгаа хайрлах сэтгэлээ нэвт шингээж, байгалийн зохицолдоог олж харах жинхэнэ монгол ухааныг мэдрүүлж чадсан онцлогтой.

Б.Баярчимэгийн анхны номыг өлгөйдөн авч, олны хүртээл болгоход хамтран ажилласан дизайнер С.Лхагвасүрэн, зураач Б.Ганзориг нарт талархал илэрхийлье.

Залуу зохиогчийн уран бүтээлийн гараа олз омгоор дүүрэн байг!

Редактор Ц.Оюунчимэг

АГУУЛГА

- 7 Нэгдүгээр бүлэг. ДУСАЛ УС
- 8 Анхны хадлан
- 10 Андуурал
- 12 Толь хад
- 15 Жолооч малгай
- 17 Буруутан
- 19 Гэмшил
- 21 Дусал ус
- 23 Хоёрдугаар бүлэг. АМЬ АВАРСАН ХОТОЧ
- 24 Аавын нутаг
- 26 Хулангийн нулимс
- 28 Хоёр өвгөний бодол
- 30 Өвгөн мод
- 32 Тэнгэрт адислуулсан хайр
- 35 Амин хэлхээ
- 37 Амь аварсан хоточ
- 39 Гуравдугаар бүлэг. МОДДЫН ДУУ
- 40 Ээж нар хоёр
- 42 Цэцэгс хайранд дэлбээлдэг
- 44 Хүүгийн зураг
- 46 Алтны судал
- 48 Цагаан тэмээ
- 50 Ухаанаар ухагдсан уурхай
- 53 Моддын дуу

ЗОХИОГЧИЙН ҮГ

Байгаль хамгаалах их үйлсэд сэтгэл зүрх, хөдөлмөр зүтгэл, үйл ажиллагаагаа зориулсаар ирсэн мянга мянган эгэл жирийн хүмүүс, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамт олон Та бүхэнтэй энэхүү бүтээлээрээ дамжуулан уулзаж байгаадаа би туйлын их баяртай байна.

Ном бичихэд минь үлгэр дуурайл болж, урам зориг, эрч хүч өгсөн ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл, өгүүллэгүүдийг минь ном болгон хэвлэхэд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн Талантбүүк ХХК-ийн захирал Ц.Оюунчимэг, номын албан ёсны нээлтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын хамт олон, орон нутгийн сэтгүүлч Д.Мишигсүрэн нарт чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд, “Хорвоо дэлхийд хүмүүн болгон төрүүлсэн хайрт аав, ээж, Хайрын энгэртээ өлгийдөн тэвэрсэн халамжит хань, Ээжийн бүүвэйн дууг аялуулсан эрх хонгор үрс, Элбэрэлт ахан дүүс, Эрдэмт мэргэн багш нар, Эгнэгт үнэнч хамт олон, найз нөхөд, Бөмбөрцөг дэлхийн хүмүүн төрөлхтөн Та бүхэндээ Үгэн сэтгэлийн уянгаар бэлэг барья.

Өглөг эдийнх бус сэтгэлийнх байх тусам үнэ цэнэтэй. Миний өчүүхэн бүтээл говь нутгийн минь хөрсөнд жимс жимсгэнийн моддыг ургуулна гэдэгт би гүнээ итгэж байна. Учир нь, “Амин хэлхээ” номын борлуулалтын орлогоос жимс, жимсгэнийн мод тарих жижиг төслүүдийг санхүүжүүлэх хандивын санг бүрдүүлэх юм. Нутгийн минь хөрсөнд ургах жимс, жимсгэнийн модод нь эх нутагт маань нүүрлэн буй элсний нүүдэл буюу шороон цөлжилт, хогийн ургамлын тархалт буюу ногоон цөлжилтийг сааруулах анхны алхам болно гэдэгт итгэлтэй байна.

Бид нэг үндэстэн биш ч, нэг дэлхийтэй билээ. Тив дэлхийн аль нэгэн хэсэгт байгальтайгаа зохисгүй харьцах бүрийд бөмбөрцөгийн нөгөө талд нөлөөлж, байгалийн гамшиг эрсдлийг бий болгож байна. Байгальтай зохисгүй харьцсаныхаа төлөөсөнд байгаль эхийн үр сад болох хүмүүсийн эрүүл мэнд, амь нас хохирч, байгаль орчинд нөхөж баршгүй хохирол учруулсаар байдаг билээ. Энэ бүхнийг хүмүүс ам дамжин ярьцгааж, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өрсөлдөн мэдээлсээр багагүй хугацаа өнгөрчээ.

Улс орон бүр өөрийн шашин шүтлэг, ёс заншил, хууль, дүрэм журмыг баримтлан байгалаа хамгаалан дээдэлдэг. Байгаль хамгаалах чиглэлээр хийгдэж буй ажлууд тэр бүр үр дүнгээ өгөхгүй байгаа нь сэтгэл түгшээх боллоо.

Хүмүүн төрөлхтөн бид нэгэн эхийн үр сад гэдгээ ухамсарлан ойлгож, цэвэр агаар, цэнгэг ус, ногоон модод, цэцэг алагласан тал хөндий, онгон дагшин байгаль дэлхийгээ ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд чадах бүхнээ хийх цаг нь болжээ.

Миний төрсөн нутаг Өмнөговь аймагт 21 дүгээр зууны их бүтээн байгуулалт өрнөж, дэлхий нийтийн анхаарлын төвд ороод байгаа нь бахархал боловч, нөгөөтэйгүүр болгоомжлох сэрэмжлэх бодлыг төрүүлж байгааг нуух аргагүй.

Нутгийнханд маань тохиолдсон бодит үйл явдлуудаас сэдэвлэн бичсэн энэхүү өгүүллэгүүдээрээ дамжуулан нийгмийн ухамсарт нөлөөлөх замаар, эх дэлхийгээ хамгаалах үйлсэд өөрийн хувь нэмрийг оруулахыг зорилоо. Эрхэм уншигч Та таалан болгооно уу.

Номын цагаан мөр, эрүүл ногоон ертөнцийг мөнхөд ивээх болтугай.

Бүдээгийн БАЯРЧИМЭГ




БҮЛЭГ

ДУСАЛ УС

.....
...Цангаж байна, маш их цангаж байна.

Гэвч ус хаана байгаа билээ?

... бага насандаа айж сүрдэн алсуурхан өнгөрдөг байсан цөөрмийн ус, түүн рүү татсан шуудуугаар хүчирхэгээр долгион урсаж ирэх цэнгээг усны чимээг санагалзан харуусч гуниглав...



АНХНЫ ХАДЛАН

*... тааныг үндэстэй нь түүвэл
дахин ургахгүй...*

Өглөөний наран мандахад, өдрөөс өдөрт улам үзэсгэлэнтэй болон тодрох тал нутгийнхаа өнгийг харан сэтгэл баясч нойр сэргэхүйд, тааны үнэр улам ч хурц болсон мэт санагдана. Саяхан ногоорч байсан тал нутаг тааны толгойд будагдан цайрчээ. Өнөөдөр бид таана түүж эхлэнэ. Урьд нь хийж үзээгүй ажил учир тал руу бушуухан гарахсан хэмээн яарч, өглөөний ажлуудаа хийж дуусгахаар шамдав. Ямаагаа сааж, малаа бэлчээн, ундны усаа ойртууллаа. Учир нь энэ өдөр миний том болсныг гэрчилж, ах эгч нарын хийдэг “том” ажилд анх удаа томилогдож байгаа нь энэ юм. Их үдийн хурц наран шарахаас өмнө хүн бүр шуудайгаа дүүргэж ирэх “эмээгийн даалгавар” аваад хоёр айлын дөрвөн хүүхэд шинэ ажилдаа шаргуухан гарлаа. Түүсэн таана маань хүнд байсан ч эмээгийн магтаал хэмээх том шагналд яарсаар, шуудайтай таанаа үүрэн ойр ойрхон амарч, хурдан алхсаар гэртээ ирэв.


Хоёр гэрийн дундах майхны хормойг нэлээд дээш шуусан харагдана. Майхны голд баруун айлын Цэвэлмаа гуай таананд явсан хүүхдүүдэд хярам хийж өгөнгөө,

- Цангав уу, ядрав уу, хол байна уу, хүнд байна уу, хүйтэн хярам уу гэсээр сууж байв. Бид ч дор бүрнээ хариулт өгөхдөө, өглөөг бодвол арай дуу султай байсан ч, бүгд шинэ “тариаланчид” болохоор хийсэн ажилдаа сэтгэл өндөр байлаа.

Хярмаа ууж дууссаны дараа, түүж ирсэн таанаа тусгайлан бэлдсэн дэвсгэр дээр асгав. Бидний түүсэн тааныг Цэвэлмаа гуай нэг бүрчлэн үзэж шалган зөвлөгөө өгч, бид ч алдаа оноогоо газар дээр нь сонсох зуур юуг ч хийсэн чин сэтгэлээсээ хийх ёстойг мэдэж авлаа. Цэвэлмаа гуайн зөвөлгөө цааш үргэлжлэн үндэстэй нь суга татан гаргаж ирсэн багц тааныг бидэнд үзүүлэнгээ,

-Хүүхдүүд минь, дахин ингэж үндэстэй нь битгий тасдаарай. Өглөө та нарт сануулж явуулаагүйгээс боллоо. Тааныг үндэстэй нь түүвэл дахин ургадаггүй юм. Дахин ургахгүй болохоор бидний иддэг махны сайхан амт алга болно. Өнөө та нарын идэх дуртай амтат өрөм ч тогтохоо болино шүү дээ. Яагаад гэвэл энэ сайхан агь тааныг идсэн говийн малын мах амттай, сүү нь өтгөн байдгаас бидний хүнс илч тэжээл сайтай, говийн хүмүүс эрүүл чийрэг, тэвчээр хатуужилтай байдаг юм гэлээ.

Зөвөлгөө дууссаны дараа хүүхдүүд ажлаа үргэлжлүүлэн, түүж ирсэн таанаа нэг хэсгийг нь ороомог хийхэд, нөгөө хэсгийг нь зоодой хийхэд бэлтгэсээр орой болгов. Ажлын явцад хамгийн их сэтгэл зовоосон зүйл бол, бидний түүж ирсэн таанын ихэнх нь үндэстэйгээ байсан явдал юм. Өдөржин гэмшсэн надад, тааныг үндэстэй нь суга татан авсан газар бүр онгойн үлдсэн нь нүдэнд харагдаж, дуртай өрмөө ч идэж чадахгүй гэхээр, ямар том хэрэг хийснээ ойлгож байлаа.



АНДУУРАЛ

*...Бүжин маань намайг харахаараа
хяран хөдөлгөөнгүй болчихно...*

Борооны дараа хурц наран шарна. Гэрийн өмнүүрх жалганд үхэр огодойнууд нэг нүхнээс нөгөө рүү огдогонууд гүйлдэх нь эгдүүтэй. Бороонд хоригдож хоёр өдөр ил гараагүй огодойнууд хоорондоо тоглон байгаа нь тэдний үлэмжийн жаргалыг илтгэх аж. Миний хувьд өдөр бүр тааралддаг тэднийгээ хоёр өдрийн борооноор хараагүйгээс үгүйлсэн бололтой. Учир нь бид өдөр бүр тааралддаг болохоор бие биенээ сайн таних болсон билээ. Гэвч огодойнууд олон тул би ялгана гэж байхгүй л дээ. Харин тэд намайг мэддэг бололтой хажуугаар нь модон морь унан хашгиран давхихад цочих ч үгүй.

Хангай дэлхий өдөр ирэх тусам тод ногоон өнгөөр дуниартаж, хөдөөний хүүхдүүдийн нүүр улаа бутран байх зуны нэгэн халуун өдөр, гэрийн гадаа хураасан шалан завсраар саваагүйхэн шагайтал эхээс дөнгөж гарсан болов уу гэмээр бүжин хярж хэвтсэн харагдав. Хайрлах, баярлах зэрэгцэн,

- Эмээ би бүжин туулайтай боллоо гэж догдлон үглэсээр гэртээ харайн орлоо.

Эмээгийнхээ,

- Юун бүжин бэ гэсэн асуултад хариулах завгүй аягандаа хярам хийн бүжиндээ өгөхөөр авч гарав. Гэтэл шалны хөндөл мод тээглэн аягатай хярам багтсангүй. Юунд хийвэл бүжиндээ хярам өгч болохыг бодов. Ийш тийш харан жаахан хайлаа. Гэрт ороод харав. Гэтэл ширээн дээрх өвөөгийн хайрцагтай тамхи нүдэнд туслаа. Яг болно гэж баярлан гүйсээр эмээ дээрээ очиж төмөр хайрцагтай мамбаса өгөхийг гуйв. Түрүүнээс хойш их ажилтай хойш урагш гүйсэн ач охиныхоо юу хийх гэж байгааг ойлгосон эмээ маань авдраа уудлан ногоон төмөр савтай мамбаса гаргаж өгөв. Баярласан надад чихрээс

үнэтэй нь төмөр хайрцаг байсан учраас хөршийн хүүхдүүдийг дуудан доторх чихрийг нь шалавхан тарааж саваа суллаад, бүжиндээ хярмаа төвөггүйхэн тавьж өгөв. Бүжин маань намайг харахаараа хяран хөдөлгөөнгүй болчихно. Таана мангирын үндэс түүж хярмныхаа дэргэд тавив. Огтхон ч хорогдоогүй байв. Түргэн шиг надад дасаасай гэж би туйлаас их хүсч байлаа.

Арваад хоног болоход миний тавьж өгсөн хярмыг ууж байгаа нь мэдэгдсэнгүй. Харин үндсээр оролдсон бололтой, тараасан байдаг байв. Гэсэн ч би өдөр бүр хярм, үндсийг үргэлж шинэчлэн тавьж, нялх амьтны гэдсийг өвтгөхгүйг хичээдэг байлаа. Нэг өдөр бүжингээ огтхон ч томрохгүй байгаа талаар эмээдээ хэлэв.

Үдээс хойш ямаагаа саахаар гарахын өмнө эмээ,

- Миний охин үхэр огодойг бүжинтэй андуурсан шиг байна. Яаж яваад ийм сайн эзэнтэй болдог азтай амьтан бэ гэв. Яагаад өдөр бүр харж байдаг амьтнаа би танихгүй байх билээ. Яг л бүжин мөн дөө гэж өөрийгөө өмгөөлөн бодов. Тэгснээ шалан завсраар шагайн бүжингээ тогтуухан харахад, нээрэн л гэрийн өмнүүр гүйдэг огодой мөн байлаа. Хэдийгээр урам хугарсан ч амьтан хайрлаж асарч үзсэндээ сэтгэл хангалуун үлдэв. Харин өвөө, эмээ хоёр маань шалан завсар ороод гарч чадахгүй байсан тэр амьтныг суллан явуулсан юм.



ТОЛЬ ХАД

*... өмнө нь тулан очвол үнэхээр
миний дүрс тэр хадан дээр харагдаж
байлаа...*

Аймгийн төвөөс Гурван сайхан уулын бэл хүртэл явснаас өөр газар явж үзээгүй намайг, эмээгийн дээ амраад ирэх хойгуур, аав маань суманд ажиллах томилолт аваад манайх гэдэг айл нүүчихсэн байв. Холбоон дээр очиж ээжтэйгээ утсаар ярьтал “Миний охин, наанаас чинь одоо унаа гарах гэж байна, суугаад ир” гэлээ.

Машинаар хол явж үзээгүй учир бөөн баяр болж хөөрцөглөсөөр явах машиндаа очиж суув. Нар жаргахаас өмнөхөн “анхны” холын аялал маань эхлэлээ. Зорьсон газар маань аймгийн төвөөс хоёр зуу гаруй километр зайтай бөгөөд энхэл донхол ихтэй шороон замаар явж очдог аж. Нар жаргаж харанхуй болсон тул эргэн тойрныг харах боломжгүй ч, эмээгийнхээ төрж өссөн нутагт очно гэхээс би туйлын ихээр яаран догдлов. Эмээ минь үзэсгэлэнт говийнхоо уул усны домгийг бидэнд олонтаа ярьдаг байснаас, ноёндоо уурласан хатан Сэврэй толио шидэхэд нь Толь хад болон хувирсан тухай домог сэтгэлээс гардаггүй билээ. Би тэр домогт газар очно гэхээс ядрахаа мартаж яаран тэмүүлж байлаа.

Нэг мэдсэн чинь хүмүүсийн дуу чангаран хэн нэг нь,

- Бороо орсон байна. Ашгүй дээ. Олон жил оторт явж нутгаа санасан малчид эргэн ирэх нь дээ гэх чимээнээр нүдээ нээн харвал, үүр хаяарч цуг явсан хүмүүс машинаас бууцгааж байв.

Хэдхэн гэрүүд урд хойд хоёр уулынхаа энгэрийг түшин бууж, уулсынхаа голд цомцойн харагдах нь төв суурин газраас ирсэн надад эль хуль санагдсан ч, агаар нь тунгалаг үнэхээр сайхан аж. Намайг хүргэж ирсэн жолооч ах,

- Танай гэр тэр байна гээд гараараа зааж өгөв. Ганц жижиг цүнхнээс өөр ачаагүй учир, би машинаасаа үсрэн бууж гэртээ гүйсээр ороход дүү нар маань,

- Эгч ирлээ гээд баярлан босоцгоолоо. Уулзаагүй хэдэн сар болсон бид бие биенээ санасан гэж жигтэйхэн. Дор бүрнээ элдэв зүйл нэгнээсээ асууцгааж, тэрүүхэндээ цэц булаацалдан шинэхэн мэдлэгээ хуваалцаж, бас өндөр намаа үзэцгээн, ер нь бүгдийг амжуулцгааж байлаа.

Энэ хооронд Толь хадыг хурдхан шиг үзэхсэн гэсэн бодол миний толгойноос салсангүй. Тэгээд,

- Толь хад хаана байдаг вэ? Эндээс хол уу? Та нар очиж үзэв үү? гэж зэрэгцүүлэн асуув. Тэд ч зэрэг зэрэг

- Би очсон

- Ойрхон, та яах гэсэн юм, үзэх юм уу?

- Таныг явбал би хамт явъя гэцгээв. Би ,

- “Явъя. Тэр сайхан газрыг очиж үзмээр байна. Эмээ нэг удаа домгийг нь ярьж өгсөн, та нар санаж байна уу?. Тэгээд наашаа явах нь гэж бодсоноос хойш л тэр гоё хадыг үзэхийг хүсээд байгаа юм” гэлээ.

Ингээд Толь хадны зүг дүү нараа даган явган аялалд гарлаа. Сумын төвөөс хойш тав орчим километр газар алхаад л очих газартаа хүрэв. Урьд өмнө нь огтхон ч үзээгүй гөлийж толийсон үзэсгэлэнт хадыг хараад гайхан алмайрч, “..бодсоноос гоё юм, яг толь шиг юм байна” гэж бодсоор өмнө нь тулан очвол үнэхээр миний дүрс тэр хадан дээр харагдаж байлаа. Харин хадны гол хэсэгт өмлөн цоолж, бутраан нураасныг хараад,

- Голхэсэг нь ч бас ийм гоё толигор байсан бол бүр ч үзэсгэлэнтэй байх байж дээ гэж харамсангүй өгүүлэхэд том дүү маань,

- Харин тийм ээ, үүнийг орос цэргүүд АКА-аар буудсан гэсэн. Муухай байгаа биз. Түрүүнд нь биднийг ирэхэд шороонд дарагдаад гоё нь мэдэгдэхгүй байсан. Одоо бороонд угаагдаад ёстой гоё болжээ гэв.

Орос цэргүүд буудсан гэнэ ээ, яагаад? Яагаад энэ сайхан үзэсгэлэнт хадыг буудсан юм бол оо? Хэдийгээр тэр орос хүн ч гэсэн бид нэг л дэлхий дээр амьдардаг шүү дээ. Тэгэхээр хаана ч, хэн ч байсан байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж байж л бид амьдрах бус

уу гэхчилэн эрэгцүүлэн бодож, туйлын их харамсав. Бидний аялалыг урамгүй болгосон орос цэрэг тэр хадыг буудаж зогсохдоо юу бодож, ямар байдалтай байсан бол гэж бодохоос эгдүүцэн, энд үдлэх төлөвлөгөөтэй байсан ч шууд буцмаар санагдав.

- За харья даа гэж намайг буйтнахад

- Тэгье, гэхдээ хэдүүлээ замаараа Пионеруул өөд гаръя.

Орой дээр нь гарахад сүртэй, бас тал тал тийшээ зөндөө гоё юм харагддаг, үнэхээр сайхан шүү гэсэн дүүгийнхээ үгийг дагав. Уулын оройд гараад, эргэн тойрныг алган дээрээ тавьсан мэт харан баясаж, Ноён нутгийнхаа сайханд биширлээ.



ЖОЛООЧ МАЛГАЙ

*...“Тэнд хэн нэгэн “Хамгаалагч”
туслаагүй бол..., хангай дэлхий олон
зүйлийг зохилдуулах юм даа*

Цагаан сарын дараахан дуниаран хөхөлбийтөж салхилсан нэгэн өдөр их үдийн хэрд Аюуш өвгөн уяан дээрээ хонины морио эмээллэж дуусаад эргэн харж, амьсгаадан гүйж ирэх ач охиноо өхөөрдсөн харцаар харж,

За ашгүй, миний охин гүйгээд ирэв үү, хонио эргүүлээд худаг дээр туугаад ир, гэснээ

Алив миний охин даарна гээд толгой дээрх “жолооч” гэгддэг үстэй савхин малгайгаа авч өмсүүлээд, охиноо өргөн моринд мордуулангуут бал алаг ухасхийн охиныг авч давхив. Сандарсан өвгөн,

Хааяд, хүүхэд... хэмээн сандран чанга хашгирсаар хоцров. Өвгөнийхөө хашгирах чимээнээр эмгэн ухасхийн гарч харвал, өвгөн худгийн зүгт маажигнан гүйж харагдав. Тэр зүг рүү нь харвал бөөн дэрс, сондуул дунд охин нь жолоогоо байдгаараа татан гэдийчихсэн, морины давхиан дунд өндөлзөн өндөлзөн байх нь аль нэг тийшээ шидэгдэхэд бэлхэн харагдахад, бас л сандран хашгирч өвгөнтэйгөө зэрэгцэн охин руугаа яарав.

Тэгтэл өвөөгийн жолооч малгай морины баруун тал руу далбагасхийн газарт ойчиход цочсон морь үргэн бусгаж охин морины зүүн тал руу шидэгдэн унах нь тэр ээ.

Хоёр хөгшин зэрэг зэрэг,

Ээ, бурхан минь, охиныг минь... гэж үглэн гүйсээр охин дээрээ очвол томоогүй бяцхан охиных нь дух шалбарч, тэр хэсэгт нь шороо наалдсан байв. Ач охин эмээ, өвөө хоёроо харан инээмсэглэсээр босч ирэв. Хоёр хөгшин охиноо зэрэг зэрэг тэврэн, тэмтчиж эсэн мэнд байгаад нь баярлан өвөө нь,

Миний охин ёстой мундаг юм аа. Малгай хийсээгүй бол ч унахгүй

нь байна шүү. Ёстой л малч удмын охин мөн дөө. Үгүй муу бал алаг минь хаврын муухай шороонд цангадаг юм байх даа, шууд л худаг руу аваад давхичих юм. Өдөр болгон л услаж байгаа даа. Мөн ч их айлаа даа, охин минь гэтэл бяцхан охин нь,

Өвөө би сургуульд орохоороо бүр мундаг болно тийм ээ, би татаад л байлаа, хавчаад л байлаа, тэгсэн ч чадсангүй хэмээн нэлээд тохь суусан хүний янзаар хэлэхэд өвөө, эмээ хоёр нудралцан жуумганаад,

За явцгаая, малаа услая гээд алхацгаав.

Ийнхүү худаг руу алхах хооронд Аюуш гуайд хоромхон хугацаанд болоод өнгөрсөн явдал нүднийх нь өмнүүр жирэлзэн, “Харин ч муу зүйл болсонгүй, охин минь зүгээр гүйж байна, эвий хүүхэд юм болохоор өвдөж байгаагаа мэдэхгүй байгаа юм болов уу” гэж бодонгоо охиноо ажигласаар л байв. Санасныг бодвол охин юу ч болсон шинжгүй өвөө, эмээгээ тойрон гүйсээр тэд худаг дээр ирлээ.

Аюуш гуай ховоогоо татан малаа услах зуураа охиныхоо ойчсон байдал, газрыг нь эргүүлэн бодсоор л байлаа. “Тэнд хэн нэгэн “Хамгаалагч” туслаагүй бол охин нь ядаж л хамаг бие рүү нь хатгахаар өргөс ихтэй хуурай сондуулын оройн цоорхой хэсэг дээр яг тааруулан ойчих уу, хангай дэлхий олон зүйлийг зохилдуулах юм даа..., байгаль өөрөө хүмүүн биднийг үргэлж хамгаалж явах юм. Харин хүмүүс бид л байгальтайгаа зөв харьцаж явбал эсэн мэнд энэ насыг элээх юм шүү дээ” гэсэн бодолд автан, дахин нэг ховоо татах зуур хөгшин нь,

Өвгөөн одоо мал ус ууж ханалаа гэж байв. Ийнхүү өвөө, эмээ, ач охин гурав малаа услаж дуусаад, өөрсдөө үдлэхээр, болсон явдлын талаар хөгжилтэйгөөр ярилцсаар гэрийн зүг алхацгаав.



БУРУУТАН

*“... Шувууны өндөг хагалсан хүний
нүүр нь цоохор болдог...”*

Үүр хаяаран наран мандаж, алтран туяарах цацраг нь амьд ертөнцийг тэр чигээр нь гэрэлтүүлсээр хаврын сайхан өдрүүдийн нэг эхлэхэд, ногоон нөмрөгөө нөмөрч, нялх ногооны анхилам үнэрээрээ гайхуулах тал нутгийн үзэсгэлэнтэй шувуудын жиргээ хослон говийн өглөөг угтах ажгуу. Өвөлжөөний орой дээр өглөө бүр уянгат хоолойгоороо донгодох өвөөлжний дуу ч тэр сайхан өглөөд чимэг нэмж байлаа.


Энэ жилийн хавар урьд урьдынхаас урт хавар болсноос Цэрэн гуайн, манай хоёр хаваржаандаа хорогдон байв. Гэсэн ч униар татан, ус булаг хоржигонон, унага төл тонгочин байх нь цаг ирж явааг илтгэх тул сүүлийн хэдэн өдөр хоёр гэрийнхэн зусландаа гарах бэлтгэлээ ханган дор бүрнээ ажилтай байлаа. Хоёр гэрийн хөгшчүүл угаас нас ойролцоо, насаараа мал малласан учраас тэр үү бидэнд заах зөвлөх зүйл мундахгүй. Тэр нь бидний амьдралд үргэлж хэрэглэгддэг хэр нь бидэнд илт анзаарагддаггүй зүйл байх нь элбэг. Харин сонсоод “нээрэн тийм шүү” гэх бодлыг эрхгүй төрүүлнэ.

Өнөөдөр миний хонинд явах ээлжтэй өдөр биш ч малаа бэлчээрлүүлэхээр голын зах хүртэл туулцахдаа дов дэрсний оройг дамжин дэвхэрч өөрийгөө зугаацуулж явлаа. Тэгтэл нүдний буланд нямбайлан зассан өвс, хялгасан үүрэнд жижигхээн хөөрхөн гурван өндөг харагдав. Нэг ухасхийн барьж авах гэснээ, томчуудын “шувууны өндөг таарвал оролдож болохгүй, сүүдрээ ч тусгаж болохгүй, хэрвээ сүүдрээ хүргэвэл эх нь голчихдог юм, хагалж бүр ч болохгүй, хагалсан хүнийг шувуу хараадаг, бас хөөрхөн нүүр нь цоохор болдог” гэж хэлдэг үг санаанд орон зог тусав. Зогсохдоо өндгөнд сүүдрээ хүрсэн эсэхийг хараад, жаахан ухарч холдон зогслоо. Хараад байхад үнэхээр эгдүүтэй хөөрхөн юм аа. Ингээд хэн нэгэнд хэлмээр санагдан гэрийн зүг гүйж

явтал саахалт айлын хоёр хүү морьдоо бариад буцаж байгаатай таарав. Тэсгэлгүй тэр хоёрт өнөөх хөөрхөн өндөгнүүдийнхээ тухай хэлээд байгаа газрыг нь ч зааж өгчөөд гэр рүүгээ яаран гүйлээ.

Маргааш өглөө нь өнөөх хэдэн өндгөө эргэхээр эртлэн босч очоод “ямар муухай хүүхдүүд вэ” гэсээр гэрийн зүг хар хурдаараа эргэн гүйв. Гэрийнхээ гадаа ирж хаяагаа түшин суугаад уйлж гарав. “Яах гэж тэр муу хоёрт хэлэв ээ” гэж харуусан бодлоо. Тэгээд ямарваа нэг зүйлийг “хэнд хэлж болох, хэнд хэлж болохгүйг бодох хэрэгтэй юм байна” гэж өөрийн эрхгүй амандаа бувтнав. Айлын хоёр хүү хэлсэн даруйд минь очоод өндөгнүүдийг хагалан, үүрийг нь эвдээд орхисон байв. Тийм муухай зүйл үзэж харсныхаа дараа айлын хүүхдүүдийг үзэн ядахын дээдээр үзэн ядаж, бас өөрийгөө буруутган зэмлэж байлаа. Сэтгэл минь нэг л хөндүүртэй зовиуртай байсаар хэд хонолоо. Манай гэрийнхэн “охин минь яагаад дуу муутай байгаа юм бол, хоол идэхгүй байна” гэхчилэн асуух үглэх зэрэгцүүлнэ.

Хэд хоногийн дараа худаг дээр хонио услан байтал айлын хоёр сагсуу хүүгийн нэг нь ирэв. Түүнийг харахаас дургүй хүрч байсан ч нүүр нь цоохортсон байх гээд сониучирхан харвал, урьд нь цоохор байсан юм уу, ямар ч гэсэн хамраа тойроод битүү цоохор харагдлаа. Гэвч түүнийг буруу зүйл хийснээсээ болж цоохортсон гэсэн бодолдоо итгэн, “Үнэн юм байна. Шувууны өндөг хагалсан хүний нүүр цоохор болдог гэж үнэн байна. Шувуу битгий хэл үрээ хөнөөлгөсөн бүх амьтан гомдож голоо тасартал бодно шүү дээ. Тэр бодлын тусгал бурууг хийсэн этгээдэд тусдаг юм байна” гэж хэлмээр санагдан зогстол “Малаа буцаагаарай” гэж хөршийн охин хашгирав.



ГЭМШИЛ

*...үргэлж хөдөөний хүүхэд гэж гадуурхагддаг
болохоороо тэднээс илүү гэдгээ гайхуулах
хүсэлдээ автав....*

Сүх элдвийг бодон, нар жаргаж сэрүү татахыг хүсэмжлэн хэвтэнэ. Удалгүй нар гудайн улаартан жаргаж маргаашийн бас нэгэн шатам халуун өдрийг зөгнөх аж. Гадаах байдлыг гэрийн хаяагаар харан хэвтэх түүний хацрыг зөөлөн салхи аргадах мэт үе үе илбэснээ, хааяа зэмлэх мэт хүчтэйгээр үлээнэ. Гадуур тоглон гүйлдэх хүүхдүүдийн дуунд сэтгэл нь баясч, тэдэнтэй хамт наадахсан гэж томоогүй насныхаа хүсэлд автавч, аймшигт өвчинд нэрвэгдсэн түүнд бүх зүйлс гунигтай.

Гэр доторх хүмүүс чимээ гаргахгүй эл хуль байх нь цаанаа л гунигтай бөгөөд аюул улам бүр ойртсоныг илтгэнэ. Өдрөөс хойш эзгүй явсан ээж мөн л чимээ гаргахгүй гэсэн шиг сэмхэн орж ирэх нь мэдэгдэв. Гэрийн эзэн Сүх, ах, эгч нар бүгд ээжийнх нь юу хэлэхийг хүлээж, асууж зүрхлэхгүй, хөдөлгөөн бүрийг нь ажиглан харна. Гэвч эхнэрийнхээ хэлж чадахгүй байгааг ойлгосон Галсан “За юу болов хө?, Довчин ламтай уулзав уу? Юу гэж байна?” гэж зэрэгцүүлэн асуув. Сүхийн ээж “Уулзлаа, лусийн хорлол болсон гэнэ ээ”, “Үгүй байлгүй дээ, яасан гэж” хэмээн амандаа сулхан дуугарав. Ээжийнхээ хэлж байгаа зүйлийн нарийн учрыг энэ гэрт Сүх өөрөө л ойлгох шиг болов.


Сүх голын гүехэн хэсгийн усан дотор жижигхэн шүүр барин зогсож жимсний үр цацахад жараахайнууд оволзон цугларна. Тэднээс шилэн савандаа хийж дүүргээд таглав. Голын эрэгт гарах зуураа жимс түүхээр явсан зуслангийн хүүхдүүд ирж явахыг харан, үргэлж хөдөөний хүүхэд гэж гадуурхагддаг болохоороо тэднээс илүү гэдгээ гайхуулах хүсэлдээ автан, урьдчилан бэлтгэсэн тулгын гурван чулуун дотор гал асаан, эгчээсээ гуйж ирсэн жижиг тогоогоо тавив. Гал дэвжин тогоо халж эхлэхэд өнөөх шилтэй жараахайгаа шууд хөнтрөн хийлээ. Тэгтэл жараахайнууд амьдаараа хурдан хурдан хөдлөн мурчиганан

ях ийхийн зуургүй халуун тогоонд шарагдан амиа алдаж байлаа. Хүүхдүүд ч нэлээд ойртжээ.

Эхний хүүхэд ирснээ Сүхийн хийсэн “гал зуух”-ыг үзээгүй бололтой “Энэ юу вэ?” хэмээн асууснаа тогооны таг авч “Хөөх, ямар гоё юм бэ?, өлсөж ирсэн юм” гэснээ “Хүүхдүүд ээ хурдлаарай шарсан загас” гэж хашгирахад араас нь ирж байсан хүүхдүүд гүйцэн ирлээ. Тэр оройгоо зуслангийн хүүхдүүд дотор нэр хүнд нь өсч, бүгд л Сүхээ, Сүхээ гэгцгээж байлаа. Гэвч үе үехэн нүдэнд нь өнөөх амьдаараа шарагдсан жараахайнууд харагдаад Сүхээгийн сэтгэл жаахан тавгүй байв. Харин тэрээр энэ тухайгаа хэнд ч хэлэхгүйгээр шийдсэн юм.

Сүхээ хичээлдээ явахаар зэхэх зуураа толинд нүүрээ харвал нүүрэн дээр нь нэлээд том газар улайсан байхыг хараад, ээжээсээ юу болохыг асуухад “Түүхий шиг л байхын” гэснээ, “Үгүй, түүхий гэхээр том юм аа, за зүгээр зүгээр, сайн ажиглаж бай” гэжээ. Гэвч шөнө нь хамаг бие нь загатнаж эхлэв. Арай гэж өглөө болгон бостол гар нүүр, хүзүү, цээж дүүрэн цэврүүтсэн байлаа. Энэ өдрөөс хойш сурагч Сүхээ биш өвчтөн Сүхээ болжээ. Гэсэн ч эдгэрэх хүсэл, итгэл найдвар нь тасрахгүй байсаар хаврыг өнгөрөөж зуны сайхан улиралтай золгоод байгаа нь энэ. Энэ хооронд сургуулиасаа чөлөө аван, эмнэлэг гэр хоёрт ээлжлэн хэвтэж эмчилгээ хийлгэсээр байсан ч тусыг эс олжээ.

Өнөөдөр тэрээр юуны учир өвдсөнөө мэдсэн. Тэрээр элдэв зүйлийг бодон хэвтэхдээ, “Нэгэнт муу зүйл хийж чадсан юм, нэг ч болов сайн үйл хийе, хүүхдүүд миний алдаанаас сургамж аваад ан амьтдыг хайрлаж хамгаалдаг болог” гэж бодон хэнд ч хэлэхгүй гэсэн шийдвэрээ өөрчилж, хаяаны ойр гүйлдэх хүүхдүүдийг дуудан гэртээ оруулж, тэнд байсан бүх хүмүүст өөрийн хийсэн гэнэн болчимгүй үйлдлийг нэгд нэгэнгүй ярилаа. Үүний дараа Сүхийн дотор бага боловч онгойж, удахгүй би эдгэрнэ. Тэгээд нэг насаараа сайн сайхан зүйл хийж, байгалийг хамгаалж, амьтныг аварч, тэжээж явна гэж өөртөө хатуу амлав.



ДУСАЛ УС

*...цөөрмийн ус, түүн рүү татсан шуудуугаар
хүчирхэгээр долгион урсаж ирэх цэнгэг усны чимээг
санагалзан гуниглав...*

Балчир ахуйдаа зуны амралтаараа өвөө эмээдээ туслангаа хонио хариулж, хорголоо хамж, хотоо цэвэрлэж байсан уулын өврийн зунжааныхаа эргэн тойрныг харан зогсож байх юм. Урьд нь бид агь, таана, шарилжийн үнэр хамар цоргисон, тааны толгойн цэцэг алагласан, эрвээхэй эргэлдэн, хэдгэнэ дүнгэнэж, голио царцаа шуугисан цэлгэр талдаа сэтгэл тэнүүн цөөн хэдэн малаа өсгөж амьдардаг байж билээ. Харин өнөөдөр зах нь харагдахгүй цэлийсэн тал биш хаашаа л харна хар бор овон довон овоолгууд алсын барааг халхлан эмх замбараагүйхэн харагдана. Гэсэн ч тэдгээр овоолгууд алтан нарыг сүүдэрлэж үл чадна. Тэр хонхорт бүтэж үхэм халуун учир хэл тагнайдаа наалдах ба омголтсон уруулаа нээж болохгүй байв. Цангаж байна, маш их цангаж байна. Гэвч ус хаана байгаа билээ. Цүнхнээсээ хуруу шилэн усны саваа гаргаж иртэл хоосон байлаа. Санаа алдан эргэн тойрноо харан, бага насандаа айж сүрдэн алсуурхан өнгөрдөг байсан цөөрмийн ус, түүн рүү татсан шуудуугаар хүчирхэгээр долгион урсаж ирэх цэнгэг усны чимээг санагалзан харуусч гуниглав. Ийнхүү зогстол гэнэт устай бороо асгарах нь тэр. Асгарсан бороо амыг минь ангайлгаж өгөв. Баярласан би усны саваа тосон борооны усаар дүүргээд, тэмээний хорголон чинээ цайны аягаа гарган усаар дүүргэж уув. Дундарсан саваа дахин дүүргэхээр сандрахад гар чичрэн, алдангуут чулуун дээр унан хагарахтай зэрэгцэн бороо гэнэт зогсов. Хонхорын уснаас ууя гэж бодон хорголон аягаараа хутгах гэтэл өнөөх тогтоол ус өнгө өнгөөр бургилан буцалж байна. Ээ дээ... нутаг минь, ус минь... Өндийн босоод гэрлээ асаан толинд харвал, зүүдэнд ирсэн харуусал тэр чигээрээ нүдэнд нь тодорч байв. Крантны усаа гоожуулж цайны аягаа дүүргэн уулаа.


Эргэн орондоо орж унтах гэсэн боловч нойр хулжиж, зүүдээ нэхэн санахуй өөрийн эрхгүй гүн бодолд автлаа. Ёргүй муу зүүд гэж бодсон

боловч бас ч бодох хэрэгтэйг үгүйсгэлгүй үргэлжлүүлэв.

Ийнхүү зүүдэлсний учир, бодол сэтгэлдээ бусдын адил олон өдөр сараар нутаг усаа хайрлан харамсаж бас эмзэглэж явсан, дээр нь нутгийн эмэгтэйн хонь хариулж явсан бага насаа дурсаж халаглан уйлсан бичлэгийг үзсэнээс болсон бололтой.

Газар нутгийнх нь багагүй хэсэг гаднынхны гарт очсон тухай ам дамжсан яриа хүмүүсийн дунд байдаг болохоор, ихэнх байгалийн баялаг маань ашиглагдаж дуусчээ гэж зүүдэлжээ. Өвөө, эмээгийнх нь зунжаа ч түүнд өртөж. Тэгээд л цэлгэр тал маань овон довон хар бор овоолго болж, айл амьтан, ус ургамал нь үгүй болжээ. Ус ховор болсон учраас бидний усны сав жижиг болж, уудаг аяга маань ч жижиг болж. Ингээд өөрийнхөө зүүднээс байж болох ирээдүйг харсан болохоор ижий байгалийнхаа унаган төрхийг улам ихээр хайрлан, нялх балчир насаа үлдээсэн уулынхаа өврийг хамгаалахаар сэтгэл шулуудлаа.





БҮЛЭГ

АМЬ АВАРСАН ХОТОЧ

...хаанаас ч хайгаад оломгүй үнэтэй бүхэн
гэрт нь л байгааг олж харсан Дандарын
нүдэнд хайр гэрэлтэж, нүүрэнд нь баярын
мишээл тодорлоо..



ААВЫН НУТАГ

*...Миний аав энэ сайхан нутагт төрсөн болохоороо
эгэл мөртлөө агуу байдаг юм байна...*

Зам халхлан, тоос угалзруулан давхилдах машинуудын тоосонд эргэн тойрноо олигтой харж чадаагүй Наран, хүрэх газраа ирмэгц говийн ганган байгалийг үзэх гэж яарсаар унан тусан буулаа. Дороос нь зөөлөн сайр хөлийг нь татан авах шиг болж, бас халуу төөнөх нь аавынхаа халуун өвөр дээр шигдэн суудаг бага насны нандин дурсамжийг санагдуулна. Энд тэнд тармагхан ургасан говийн ногооны тачир хэр нь хамар нэвтрэм тааламжтай сайхан үнэр илтэд мэдрэгдэхэд гүнзгий гээч нь амьсгалж, тэр хавийн агаарыг шуналтай нь аргагүй соров. Цааш алхлахад саяхан хөл шигдээд байсан зөөлөн сайр нь том том чулуутай газар болон үргэлжлэв. Түрүүнийхийг бодвол чулуутай болохоороо хөл шигдэн орох нь арай л бага. Доош тонгойн нарийн сайн харвал, говийн бор шаргал чулуунууд нарийн элсэнд шургалан байх нь эвлүүлж тавьсан тоглоом шиг харагдана. Шаргал өнгөтэй, бөөрөн хэлбэртэй, дотогш нь хээлэн ухсан мэт, гарын алганд багтахгаар нэгэн чулуу нүдэнд нь тусахад, түүнийг аавдаа аваачиж өгөх хүсэл төрлөө. Гэтэл өвөөгийнх нь “Чулуу байрнаасаа хөдлөхөөр гурван жил нутгаа олдоггүй” гэж байсан нь санаанд оров. Нээрэн чулуу хүртэл нутгаа, “нөхдөө” санадаг юм байна. Тэгэхээр аав минь энэ сайхан нутгаа ямар их санадаг бол хэмээн бодлоо.

Наран ирэх замдаа хамт яваа нөхөддөө,

- Миний аавын нутаг байгаа юм. Аав маань нутгаасаа эрт гарсан. Ер нь нутагтаа ирэлгүй удсан. Манай аав айлын том хүү болохоор ах дүү нар ч аавыг бараадаад бүгд хотод суудаг болчихсон гэж хэнэггүйхэн ярьж явсан тэрээр говийн хангайд ирүүтээ уулга алдав. “Аавыгаа дагуулаад ирдэг байж, хичнээн их баярлах байсан бол доо миний аав, энэ сайхан нутагт төрсөн болохоороо эгэл мөртлөө агуу байдаг юм байна. Аав минь нутгаа санахдаа номоо барин цонхоор

харан зогсдог байх даа, өгүүлшгүй энэ үзэсгэлэнт нутгийг саналгүй ч яах вэ дээ. Ер нь аавыгаа нутагт нь нэг авч ирье, үргэлж бидний төлөө, ажил гэж явсаар нутагтаа ирээгүй удсан. Аавыгаа баярлуулъя” гэж шийдмэгхэн бодлоо. Наран дороо эргэлдэн, энд тэндхийн торойсон шоройсон бүхнийг ажиглан хорвоотой анх танилцаж буй бяцхан охин шиг сониучирхан байх зуураа, өөрөө энэ нутагтай ямар нэгэн нууцлаг шижмээр холбогдон буйгаа мэдэрлээ.

Ханалан хүрээлсэн дүнхэр том уулын завсар орших аавынх нь нутагт байгалийн үзэсгэлэн бүрэн цогцолсон ажээ. Уулын оройн хадан дээр нэгэн янгир сортолзон чимээ чагнан зогсохыг харав. Янгир харахаас илүү сонсох мэдрэхүй нь илүү хөгжсөн амьтан учраас чих нь сонор байдаг тухай уншиж байснаа саналаа. Уулын оройгоор томоос том шувуу эргэлдэн нисэх нь сүрдмээр. Хоёр уулын завсарт намханаар хүрхрээлэн, мяралзан урсах рашаан усны чимээ аялгуут хөгжим мэт сонсдох авай. Уулын энгэрийг ногоон хучлагатай торго гэмээр, энгэр даган ургасан бут нь торгоны хээ нь гэмээр үзэсгэлэнтэй. Бутан дороос бултганан гүйлдэх зурамнуудыг ээжийнхээ өвөр дээр тонгочин тоглох хүүхэд гэмээр. Аянчин гийчдээс айж цочсон туулай аврал эрэн ахин ахин зогсож эргэн харснаа цааш дэгдэн одох нь аюулгүй гэдгийг мэдсэн мэт. Хавчлаас гаран цааш тал дундуур давхихад усан долгио туялзан харагдана. Тэртээд ихээ ус харагдах бөгөөд цуг явсан хүмүүсийн нэг нь “Тэр нуур дээр очиж сэрүүцэе” гэлээ. Нутгийн жолооч тайван агаад бахархсан өнгөөр “Говийн зэрэглээ гэдэг чинь энэ дээ” гэв. Аялагчид бүгд дуу алдан, харах гэж хичээн өндөлзөцгөөв. Бас л говийн нэгэн гайхамшиг байлаа. Зам үргэлжлэн жирэлзэж, түмэн өнгөөр өөрчлөгдөх говийн үзэсгэлэнт байгаль аялагчдыг бишрүүлсээр явав. Хэсэг яваад замын хоёр талаар өндөр өндөр ургасан нов ногоон бутнуудтай газарт буудаллав. Шаргал элсийг гараараа барьж үзлээ, алга гижигдэн хурууны завсраар урсан буух нь намайг үлдээгээрэй гэх шиг. Үелэн үелэн хээлэгдсэнийг нь харахад гайхалтай уран сийлбэр мэт. Энэ бүхнийг харсаар жаргалын наранд хайлах шиг болсон Наран өөрийн эрхгүй уулгалан, алгаа хавсран залбирч, аавынхаа нутгийн газар шороонд мөргөв. Баясал бахархалын гялбаанд самсаа нь шархиран огшиход, анисганд нь мэлтэгнэсэн баяр бахдалын тунгалагийг сувдан дусал болгож элсэн манхандаа үлдээлээ.

ХУЛАНГИЙН НУЛИМС

...“Энэхэн хөндийдөө чи бид л хоёр бие биенээ түших болж дээ”...

Наран мандахад, ов товхон ногоон довтой говийн элст хөндий цаанаа л энхэр дотно сэтгэлийг төрүүлэх нь нэн таатай. Хэдий таатай ч сэтгэл дундруулах тэр нэгэн мэдрэмжийг тээсээр олон жилийг ардаа орхиж дээ. Энэ бол эхээс унан өлгөйдүүлж, өсөж торнисон, өөрийн бүхнээ босгосон нутгаа, газар шороогоо санасан сэтгэл билээ. Мөнхөө өвгөн өглөө бүр сурсан дадлаараа гэрийн хаяаг түшин хэдэн тийш нямбай гээч нь дурандан өнгөрүүлсэн амьдарлаа, төрж өссөн нутгаа дурсан санагалзаж элдвийг бодон зогсох дуртай. Ийнхүү зогсохын учир гэвээс тэрүүхэн элсэн дундах өнчин гэмээр жижигхэн цохион дээр умард зүг рүү ширтэн зогсох хулангийн ганц азарга өөртэй нь ижил бодолтойг илтгэх шиг.

Арван хоёр жилийн өмнө Мөнхөө Хүрмэний өмнөх говийн байгаль хамгаалагчаар томилогдож, энэ хөндийд нутагшаад удаагүйхэн байв. Мөнхөөд, өдөртөө гурван удаа морио унан өөрийн хамгаалдаг бүсийн аль нэг зах дээр ирэн орчныг ажиглан харах, дурандахаас өөр хийгээд байх ажил үгүй. Түүний ийнхүү явах бүрт онгон цэнхэр хөндий нь огтоос тайван мишилзэж, зэрэглээтэн мяралзах нь үнэнхүү бахдууштай бөгөөд сэтгэл омогшуулам билээ. Зуны эхэн сарын нэгэн сайхан өглөө Мөнхөө дурангаа барин гарч, хол ойрыг харан ажлаа эхлэв. Тэгтэл тэднийхээс холгүй нэгэн хулан харагдлаа. Тэр ийш тийш харан соргог чихээ солбиулан, хол ойрын чимээ чагнаж байгаа нь харагдав. Сайтар ажиглан харвал хулангийн гүү бололтой. Тун удахгүй унагалах болсон нь мэдэгдэж байв. Цааш лавшруулан ижил сүргийг нь хайв. Гэвч ойр тойронд нь энд тэнд тармагхан ургасан харганаас өөр зүйл харагдсангүй. Тэгээд сүргээсээ зугатан унагалахаар эзгүй говийг зорин ирсэн хулангийн гүү болохыг мэдэв. Харин яагаад гэрийн ойр байгааг нь гайхан бодлоо.

Хулангийн сүрэг азарганыхаа “үгнээс” гарна гэж үгүй, азарга нь

гүүнүүдээ бусдаас харамлаж юу ч хийхээс буцдаггүй. Тийм болохоор өөр азарганы унага тээсэн гүү сүргээсээ зугатан, ойр амьтангүй газар унагалаж үр төлөө хамгаалахгүй бол сүргийн эзэн азарга нялх унагыг тас цавчин хөнөөдөг билээ. Түүнээс зугатсан эх гүү тэргэл сар мандсан нэгэн шөнө унагалжээ. Эх гүү, унага хоёр хоёулхнаа ч гэсэн эх үрийн элбэрэл дүүрэн, тэрүүхэн нутгаараа бэлчээрлэн жаргалтай нь аргагүй амьдрал үргэлжилсээр...

Зун цаг дуусч, намрын өнгө орсон өглөө Мөнхөөгийн сэтгэл нэг л гунигтай, босох дургүй ч заншил ёсоороо дурангаа барин гарлаа. Тэгтэл унага нь газар цавчлан эхээ тойрон байх ба эх нь огтхон ч хөдлөхгүй байгаа харагдав. Эх хулан тэднийхийг бараадан байсны учрыг ойлгон өрөвдөх шиг болж, “Энэхэн хөндийдөө чи бид хоёр л бие биенээ түших болж дээ” гэж эрхгүй шивнэв. Тэр цагаас хойш Мөнхөө өглөө бүр ажлаа хийхдээ өнчин унагыг заавал дурандаж бодлоо хөврүүлдэг болсоор нэгэн үеийн он цагийг саажээ.

Зах нь харагдахгүй урт хашаан дотор олон гэрүүд байх ба өвөрт нь төрж, өссөн довцог, шанхат бор уул нь харагдахгүй байв. Төрсөн газраа хөрвөөх түүний хүсэл биелэхгүй болсныг мэдэрсэн өвгөний самсаа шархирмагц, хацар даган урссан нулимсаа нударгаараа арчин тайвширахыг оролдов. Хашаа даган нэлээд алхласан ч дотор нь орох арга алга. Харин тэгтэл түүний өмнө “найз болсон” хулангийн унага нь толгой хаялан ялаархан, цомбон хоёр туурайгаараа доорхи газраа цавчилан зогсох нь “Ээ дээ, ээжийн минь нутагт татаалын ус байдаггүй юм байх даа” гэж байх шиг санагдав. Өвгөн түүн рүү улам ойртсоор байлаа. Түүний нүднээс нулимс гарч байхыг үзвэл, бас өөртэй нь адилхан бодож байх шиг. Олон жил нэгэн хөндийд нутаглан, бие биедээ ээнэгшин дассан тэд орчлон ертөнц дээр хамгийн дотно найзууд аа.



ХОЁР ӨВГӨНИЙ БОДОЛ

*“...би гэдэг хүн энэ ойг анх тарьж байсан
хүмүүст хэчнээн ихэмсэг, тоомжиргүй ханддаг
байлаа даа...”*




Хуучирч муудсан ч жижигхэн хотыг цагтаа чимэн хамгийн өндөр барилга байсан гэгддэг гурван давхар барилгад идэр наснаасаа эхлэн өнөөдрийг хүртэл хамт яваа гэж хэлж болохоор хоёр өвгөн амьдарна. Нэгийг нь Ли нөгөөг Балжир гэх. Энэ хуучин барилга урьд нь Балжир өвгөнийх байсан ба одоо Лигийн гэр бүл амьдардаг болжээ. Балжир Лигээс арваад насаар ах. Гэсэн ч Балжир Лиг “Та” хэмээн бөхөлзөн тонголзож, өрөвдөлт нүдээр царайчлангүй харна.

Өнгөрсөн бүхэн бахархал, харуусал үлдээдэг хорвоо юм хойно Балжир өвгөн элдэв нэгийг бодон гуниглаж, цонхоор харагдах урт шигүү ойн моддыг ширтэн сууна. Ийнхүү суухдаа дотор нь үе үе харанхуйлж өөрийгөө зэмлэнэ. Тал дүүргэн найгах их ойг хараад таагүй дурсамж нь сэргэдэг ч, харахгүй байж бас үл чадна. Гэсэн ч өөрийгөө өмөөрөх сэтгэлдээ дийлдсээр гаднын хүмүүс төдийлөн орж гардаггүй энэ байшингаас хаашаа ч гарахгүй өөрийгөө хорьж, гагцхүү цонхоор л харан хэдэн цагаар ч хамаагүй зогсоно. Үгүй гараад ч яах билээ. Цус нэгтэй биш ч, түүнд Ли-гээс өөр хүн байхгүй болжээ.

Нэгэн цагт цөлийн дундах тал байсан газар нутгийн энэхэн хэсэгт нэгэн ухаант залуугийн гар сэтгэлээр ой мод болон ургаж, амьд байгалийн сэрэхүйгээр ан амьтан цуглан, байгалийн мэт хиймэл горхи урсаж ногоон ертөнцийн үзэсгэлэнг бүрдүүлж чаджээ. Энэ ойг харахад сайхан ч бодоход сэтгэл өвдөөд байгаагийнхаа учрыг Балжир өвгөн л өөрөө мэдэх бөлгөө. “Хүн гэдэг мунхаглан жудаггүйтэх үедээ юуг ч устгаж мэдэх амьтан шүү. Тэр үед би мод тарих ажил зогсоход хүргэсэн шийдвэр гаргаж билээ. Гэхдээ ч би нутаг орныхоо төлөө бие хайргүй явсан минь үнэн шүү” гэхчилэн өнөөх л өөрийгөө өмөөрөх сэтгэлдээ дийлдэнэ. Чинхүү үнэнээр өөрийгөө чагнаж чаддагсан бол,

тэрээр яг одоо л бүхнийг ухаарах аж. “Нэгэн ухаантан, хүн мөнх бусын өмнө эргэж нэг хардаг. Тэр цагийг ирэхэд харамсах зүйл багахантай л амьдрахсан” гэсэн байдаг. Гэтэл би гэдэг хүн энэ ойг анх тарьж байсан хүмүүст хэчнээн ихэмсэг, тоомжиргүй ханддаг байлаа даа. Тэгээд л баялагт шунан, мөнгөнд өөрийгөө өлгийдөх гэсэн юм шиг цуглуулж, мөнхийн хутгийг олсон мэт явсан үе бий. Тэр үед өмнө хойно минь орон, өргөх шахан гүйдэг байсан олон хүмүүсээс энэ Ли л надад үүдээ нээж” гэж бодоход хоёр нүднээс нь өөрийн эрхгүй нулимс бөмбөрөв.

Цонх ширтэн бодолд дарагдах Балжир урсан гарах нулимсаа хүн харчих вий гэсэн шиг ханцуйгаараа хурдан гээч нь шавхардан арчихыг харсан Ли, “Энэ хүн цагийг эзэлсэн шиг явсан сан. Гэхдээ ч яг тулахаараа мөн ч сайн хүн байсан даа. Намайг ч, миний гэр бүлийг ч маш том “ангалаас” аварсан. Тэгээгүй бол би гэдэг хүн энэ хорвоогийн тоосыг өдий болтол хөдөлгөж яваа ч уу, үгүй ч үү, ямар ч байсан надад ус уух хувийг хүртээсэн өвгөн ах минь, таны ачийг мартаггүй явсаар энэ хүрлээ дээ ” гэж бодсон ч Балжир өвгөний шаналан байгааг мэдээгүй дүр эсгэн суух авай.



ӨВГӨН МОД

*... Дахин мод болон ургах хүсэл нь биелнэ гэдэгт
итгэн өөрийн ирж тогтсон хонхортоо тухлан
хэвтэх түүнийг өвгөн цэцэрлэгч шүүрэн авч
хорвоо ертөнц дахин харанхуйлав...*

Удаан хугацааны туршид хаана байгаага ч мэдэхгүй түнэр харанхуйд оршин буй тэрээр, өнгөрсөн аз жаргалаа нэгд нэгэнгүй дурсан бодов. Навч цэцгээ дэлгэж, шувууд чуулуулж, хэрэм, сармагчин дүүлүүлж явсан үлгэрийн ертөнцдөө дахин амьдрах хязгааргүй мөрөөдөлдөө автан байтал гэнэт гэрэл цэлсхийв. “Ээ, мөрөөдөл минь биелэх нь” гэж баярлан бодтол, нарийхан сүмбэн цагаан хуруунууд зөрөлдөх шиг болмогц тэсэхүйеэ бэрх өвдөх нь урьдын хөрөөдүүлэх, тасдуулах, бутлуулах, живэх, жигнүүлэх зэрэг туулсан зовлонгийнх нь дэргэд юу ч биш байлаа. Дахин харанхуйд орчихов. Түрүүчийнхээс өөр нь чийгтэй, бөгчим халуун орчин. Харин энэ удаад удсангүй гэрэлд гарав.

“За одоо боллоо доо” гэж бодтол аймшигт сүүдэр ойртон ирж дахин харанхуй нөмөрч, ёолон дарагдангуутаа гэрэлд гарав. Энэ мэт олон давтагдсаны дараа гэнэт хуй салхи исгэрэн, түүнийг ороон авч эргэлдсээр арай гэж дахин газардлаа. Тэнд нам гүмхэн, чийглэг танил орчин тосон авсан нь сэтгэлийг баясгана.

Өвгөн цэцэрлэгч моднуудыг хүүхэд шигээ хайрлан тэдэнтэй ярилцах бөгөөд байнга услан арчилж, ойр орчныг нь цэвэрлэх аж. Дахин мод болон ургах хүсэл нь биелнэ гэдэгт итгэн, өөрийн ирж тогтсон хонхортоо тухлан хэвтэх түүнийг өвгөн цэцэрлэгч шүүрэн авч хорвоо ертөнц дахин харанхуйлав. Өвгөн энэ зуураа “Аа, чи минь ойрд царай муутай байсан нь энэ муухай чихрийн цаас ёроолд чинь шигдсэнээс болжээ” гэх нь сонсогдов. Тэгээд хачин муухай үнэртэй битүү орчинд шидэгдэх нь тэр.

Урьд нь тэр үзэсгэлэнт өнгөөр гэрэлтэж, анхилам үнэр ханхлуулан, уянгат дууг эгшиглүүлдэг байлаа. Харин одоо түйрэнд дарагдан хорчийсон, байгаа газрынх нь үндэс хатаж, илжирсэн үнэр ханхлуулан байх түүнд ойртох амьд амьтангүй болсон нь үнэнхүү гунигийг төрүүлнэ.

Ойн олон моднууддаа ахмад нь хэмээн хүндлэгдэж, бусдад үргэлж баяр баясгалан бэлэглэдэг байсан тэрээр, өөрийнхөө мод биш чихрийн цаасны хог гэдгийг цэцэрлэгч өвгөнөөс мэджээ. Эх байгалийн хайртай хүү элдэв зовлонг туулан гарсан ч, эргээд мод болон ургах мөрөөдөл нь хэзээ ч биелэхгүйг ухаарав. Тэгээд зогсохгүй түүний байгаа газрын орчимд ургамал мод, цэцэг жимс дэлгэрэхгүйг мэдэн гашуудаж, орсон хогийн савандаа улам шигдэн хэвтэхдээ, анх түүний сүүдэрт тоглож өссөн атлаа, алаг дэлхийг чимсэн ногоон өнгөнөөс нь үүрд салгасан ах дүү хоёр залууд гомдож уйлан хайллаа.



ТЭНГЭРТ АДИСЛУУЛСАН ХАЙР

*...Голын эрэг дээр сүртэй нь аргагүй сүглийн байдаг
өнчин ганц хайлаас алга болсон байсанд тэр зүгт
айх гайхах зэрэгцүүлэн өөрийн мэдэлгүй хурдан
хурдан алхав...*

Саяхан дээрээс цог унах нь гэмээр шарж байсан наран уулын цаагуур алгуур алгуураар далдарлаа. Саранд өдрөөс хойш наран жаргах хүртэл жаран өнгөрөх мэт санагдав. Хүүхдүүдээ хурданхан унтуулчихаад болзоот газраа түрүүлэн очих гэж яаран тэмүүлэх Саран бүсгүйн зүрх цээжиндээ багтаж ядан, хажууд нь байгаа хүнд ч сонсогдохоор цохилно. Өдөр голын эрэг дээр байхад нь янагийн холбоот Дорлиг нь ирж усны савыг нь дүүргэлцэнгээ Балсанг эзгүйг мэдэн олзуурхаж, “Өнөөдөр уулзъя” хэмээн аяархан хэлсэн нь Саран бүсгүйг ингэтэл нь догдлуулжээ. Харуй болохыг хүлээн цаг өнгөрч өгөхгүй, хичнээн ч удаа орж гарсныг мэдэхгүй, тушаатай тэмээ усанд яарахтай адил л байлаа.

Үсээ толийтол нь самнаж, наадамд өмсдөг үзмэн хүрэн торгон дээлээ өмсөөд гэрийнхээ хаалгыг сэмээрхэн хааж, голын эрэг дэх өнчин хайлаасыг зүглэн алхлаа. Гүйх алхах хослуулсаар өнөөх модны дэргэд ирэн зогстол, гэнэт хаанаас гарсан нь мэдэхгүй, хаашаа харсан нь мэдэгдэхгүй салхи дэгдэн модны мөчрөөр шавхуурдаад өнгөрөхөд нь ихэд аягүйрхэв. Гэсэн ч дотроо “Намайг энд ирэхэд хангай дэлхий хилэгнэж байгаа юм байх даа, би ер нь юугаар дутсан хүн билээ, сайн ханийн халамж ихэдэх үү гэхээс багадаагүй.

Балсан биднийг хүний дор оруулахгүй, байх чадлаараа л зүтгэж

байна. Дорлигийг ирээгүй дээр буцдаг юм билүү. За яах вэ, ирэг, өнөөдрөөс дахин уулзахгүй гэж хэлье” гэж бодон зогстол “хэмм” гэх Дорлигийн хоолой засах дуу гарч, хөлийн чимээ нь тодроход бүсгүй түрүүхний бодлоо мартан догдоллоо.


Дорлиг дөхөж ирэнгүүтээ түүний гараас барин өөр рүүгээ татаж, тэврэн авах нь тэр. Удаан уулзаагүй амраг хоёр бие биедээ шунан наалдаж, хорвоогоос тасран жаргалын мананд мансууран умбана. Гэтэл гэнэт салхи хүчтэйгээр исгэрэн шүүгэж, бөөн хар үүлс одот тэнгэрийг омголон сартай нь хучин авлаа. Цахилгаан цахиж, аймшигтай хүчтэйгээр тэнгэр нүргэлэн дуугарч, аадрын том том дуслууд амраг хоёрыг шавхуурдаж эхлэв. Ганц хором ч болсон жаргаж амжихын хэмжээлшгүй шунал хүсэлдээ дийлдсэн тэд галав юүлсэн ч мэдэхээргүй мансуурч байлаа.

Үүрийн цагаан гэгээ татах үеэр улан дороос дээшлэн өндийх нарны туяа урд шөнө уурлаагүй мэт тайван цэнхэртэх хөх тэнгэрийн өнгийг тодруулан гэрэлтүүлнэ. Урд шөнийн бороонд хоригдон замын айлд хоносон Балсан гэртээ ирэхэд, өрхөө бүтээгээгүйгээс гэр дүүрэн ус цэлийжээ. Бага охин нь түрүүлээд сэрчихсэн орон дээрээ нүцгэн шовойж суулаа. Эхнэр нь байсангүй. Гэртээ ч хоноогүй бололтой. “Ээж нь хаачсан” гэж асууснаа хариултыг нь ч сонсолгүй хажуу айл руу алхав. “Эмээ Саран харагдав уу” гэж их л хичээж асуув. “Үгүй хүү минь. Өглөөнөөс хойш харагдсангүй” гэв.



Балсан дөрвөн зүг найман зовхист саравчлан харснаа, өврөөсөө дуран гарган эхнэрээ хайв. Эргэн тойрноо харсан ч юу ч харагдсангүй. Харин голын эрэг дээр сүртэй нь аргагүй сүглийн байдаг өнчин ганц хайлаас алга болсон байсанд тэр зүгт айх гайхах зэрэгцүүлэн өөрийн мэдэлгүй гүйв.

“Ээ бурхан минь, юу болох нь энэ билээ”. Эхнэрийнхээ өрөөсөн гутлыг барьсан Балсан юу хийхээ мэдэхгүй, аянганд цохиулсан мод байсан мөнөөх газрыг алгаараа илбэн тэмтрэв. Айлын эмээ ч араас майжиганан ирж амжсан байлаа. Тэр “Тэнгэр адислажээ, хөөрхийсийг” гэснээ маани уншин, эрихээ эргүүллээ.



АМИН ХЭЛХЭЭ

*..байгаль ээж түүнтэй амин хэлхээтэй
учир дахин амьдруулж байх шиг санагдахад
баярлан босох гэж оролдов...*

Баатар нэг сэртэл хамаг бие нь хөшиж, хөдлөх гэсэн боловч чадсангүй. Гэвч “Би амьд байна, Би амьд байна” гэж баярлан бодож, хүч орон цээжээрээ өндийж ойр орчныг харав. Нэг гар нь тохойгоороо нугаларан бугуй хэсэг нь дарагдан ойчсоноос мэдээгүй болсон мэт байлаа. Арай гэж нөгөө тал руугаа биеэ өргөж гараа сугалан авав. Азаар ногоон дээр ойчжээ. Аманд ч ногоо амтагдана. Тэгснээ чамайг сэргээсэн ачтан чинь би байна гэх шиг зөөлхөн сэвших салхинд найгах ногоо хацар илбэнэ. Тэр хамт байлдаж явсан нөхдөө яасан бол, дайснуудыг хааж чадсан болов уу, би яасан юм бол гэхчилэн бодоод өөрийгөө яагаад энд хэвтэж байгаагаа мэдсэнгүй. Ямар ч гэсэн шархадсан бололтой. Цаг хугацаа хэр өнгөрснийг ч мэдсэнгүй. Хамгийн сүүлд нар жаргах болж байсныг л бүдэг бадаг санав. Одоо нар нэлээд гудайсныг бодоход их удсан бололтой.

Хаана байгаагаа, ойр хавьд хүн байгаа үгүйг мэдэх гэж бодон дахин өндийлөө. Гэвч хавь ойрд нь хүн байхгүйг ойлгов. Харин дайсны өмнөөс гүйж явахад өмнөхөн нь дүрвэгсдийн гэр байсныг санаж, тэр зүгт харвал ойрхон харагдаж байв. Баярлан босох гэтэл чадсангүй тул шууд мөлхөж, бага багаар урагшилж эхлэв. Хичнээн хэцүү байсан ч амьд гарахын хязгааргүй хүсэл нь бүх өвдөлтийг мартуулан урагшилсаар байлаа. Нар шингэхтэй зэрэгцэн гэрийн эсгий үүдэнд тулж ирлээ. Толгой гар хоёроороо хамжин эсгий үүдэнд завсар гарган харвал баруун талд нь доороо хөндөлтэй намхан модон ор бүдэгхэн харагдаж байлаа. Тийш зүтгэн мөлхсөөр дэргэд нь очиж хэсэг амсхийв. Тэгснээ гараараа тулан хүчилж орон дээр гарлаа.

Маш их даарч, толгой хагарах шахан янгинаж, бүх бие нь шархиран өвдөж, тэсэхүйеэ бэрх байв. Нүдээ нээн харвал сарны гэрэлд гэр доторх зүйлс тодоос тод харагдана. Эсгий үүдний завсраар сарны

гэрэл тусах нь Баатарт амьд үлдэх итгэлийг төрүүлнэ. Тэр гэрлийг харан хэвтэж байтал гэнэт ямар нэг амьтны сүүдэр түрүүлэн тусахад хамаг бие нь арзасхийх шиг болов. Гэвч айх хэрэггүй, би байна гэх шиг жижигхэн зэрлэг муур эргэлзсэн янзгүй гэрийн зүүн хойморт тооноор туссан гэрэлд очиж хэвтэв. Түүний тайван байгаагаас үзвэл, унтаж байх үеэр нь орж гарч гаднын “гийчин” байгааг мэдсэн нь илт.

Шархандаа халуурч бие нь улам суларсаар байв. Орон доогуур нь ойр ойрхон пад пад хийх чимээ гарах шиг болоход өндийн харах гэж оролдсон ч чадсангүй.

Ухаан алдсан, унтсаныг мэдэхгүй нэг сэрэхэд бие нь илт хөнгөрөн толгойны өвчин намджээ. Их хөлөрсөн бололтой. Бүх бие нь норсон байлаа. Толгойгоо өргөн гэр доторхыг ажиглан хартал орных нь хөл хавьд хортой могой үхсэн хэвтэв. Харин толгой хэсгийн газарт өнөөх муур амьсгаагүй болсон байв. Орон дээгүүр нь муурын үс бутарсан байхыг харснаа сая бүх учрыг ойлголоо. Тэр могой өөрийнх нь аминд хор хүргэх гэж байснаас муур өөрийг нь хамгаалж, орон доороос гаргах гэж тэмцэлдэн өнөөх пад пад хийх чимээг гаргажээ. Хөөрхий муур могойг дарсныхаа дараа түүний өвөрт орон бүх өвчнийг нь өөртөө авсныг ойлгон харамсахын дээдээр харамсаж, бас түүнд баярлахын дээдээр баярлаж байв. Баатар юу болсныг эргэцүүлэн бодож эхлэв. Дайралтад ороод шархдаж унахдаа ногоон дээр унасан нь түүний шархыг түргэн эдгэхэд тус болжээ. Биед нь дарагдсан ногооны шүүс шарханд нь түрхэгдэж хурдан илааршуулж, харин хөөрхий муур халууныг нь өөртөө аваад амь хальжээ. Ийнхүү Баатарыг энэ удаад байгаль ээж түүнтэй амин хэлхээтэй учир дахин амьдруулж байх шиг санагдахад баярлан босох гэж оролдов. Арай гэж хөл дээрээ тэнцэн босч, эсгий үүдийг өргөн гарч, ургах нарны цацраг бүрийг өөртөө шингээх гэсэн шиг алдлан зогсохдоо “Эх орон минь, эх байгаль минь чамайг үеийн үед үүрд хамгаална” гэж монгол цэргийн ёсоор тангараглан, сэтгэлдээ шивнэж байлаа.



АМЬ АВАРСАН ХОТОЧ

*...Гэнэт түүн рүү нэг амьтан дайрах шиг болж үсрэн
энгэрт нь цойлоход дотор нь палхийн цочиж балмагдсан
ч баярын од гялбах нь тэр...*


Хүүглэн исгэрэх салхины хүч нэмэгдэх тусам цасан бөмбөлөгүүд хацар цаламдахад, сормуус цантаж нүд таглан, эргэн тойрон алд хүрэхгүй газраас цааш харагдахгүй болж урагшлахуйяа бэрх болов. Дандар арга буюу доош сөхрөн бөгтийн суув. Нүүр чихээ гараараа таглан бөгтийсөн тул шуурганы чимээ түр алслах зуур өдөржин мал эрэн явган тэнэсээр нүдгүй балбах цасан шуурга эхлэхэд харьж амжаагүй тэрээр өөрийн эрхгүй зүүрмэглэв. Гэвч гараараа газар алгадан цочиж, цаг агаарын байдал улам дордохыг ойлгон битүүхэн айдаст автсан ч, төрж өссөн нутаг ус минь намайг ивээж аварна гэсэн найдлага төрөв. Тэр зуураа энд суугаад байж болохгүй юм шүү дээ гэж зэрэгцүүлэн бодож босох гэтэл бараг цасанд булагдсан байв. Цасыг сэгсрэн босч шуурга намдахыг хүлээгээд суугаад байвал хөлдөх аюултай болохоор хаашаагаа мэдэхгүй ч салхины чиг уруудан алхалж гарлаа.


Тэнгэр битүү харанхуй тул цаг хэд болж буйг мэдэх аргагүй ч үдэш болж байгаа нь мэдэгдэж байлаа. Нэгэнт зүгээ алдсан Дандар шуурга намдтал алхаад байхаас өөр аргагүй байв. Шуурга эхлэхээс өмнө гэрийнхээ баруун хойд зүгт алхаж байсан учраас шуурга уруудан алхсаар байв. “Тэнгэр хэзээ онгойх юм бол, буцаж амжаагүй шуургатай таарчихлаа. Эхнэр хүүхдүүд маань шуурганд тохитой байгаа болов уу, хэдэн бага малаа хотлуулж чадсан болов уу, надад санаа нь зовоод шуурганаар эрэлд гарч өөрсдөө аюулд өртөх вий” гэхчилэн ар гэр рүүгээ санаа зовно.

Шуурга улам хүчтэй эргэлдэх нь “Би өнөөдөр намдахгүй” гэж хэлэх мэт. Салхи уруудан алхаж байгаа хэдий ч гуталд наалдсан цас хөл дороос хүндрүүлэн татаж, хамаг бие нь сульдан ядарч буй нь мэдрэгдэж байлаа. Гэсэн ч амиа өөрөө л хамгаалахаас өөр замгүй

болсон тэр бэдчин, бүдчин жаахан ч болов урагшилсаар байв. “Хэрэв тэнгэр онгойхгүй удвал өглөөний дулаанд найдан, бас их алхахад зузаан хувцас хүнддэнэ гэж дулаан хантаазаа тээр шаан ганц дээлтэй гарч ирсэн би гэдэг хүн өглөөтэй залгаж чадна гэж үү” гэж бодохоор айх шиг болно. Гэвч тэр амь аврагдах итгэлээ алдахыг хүссэнгүй.

Гэнэт түүн рүү нэг амьтан дайрах шиг болж үсрэн энгэрт нь цойлоход, дотор нь палхийн цочиж балмагдсан ч баярын од гялбах нь тэр. “Хүүе, банхар минь, чи хаанаас гараад ирэв ээ” гээд нохойгоо тэврэн авлаа. “Чи намайг яаж олов, гэр хаана байна, бага малаа хотлуулсан уу” гэхчилэн ар араас нь асуув. Харин Банхар намайг дагаад яв, гэх шиг өмнө нь оров. Түүнийг даган бэдчиж саахалтын хэрийн газар явсаар гэрийнхээ үүдэнд ирэхэд, эзнээ тойрон сүүлээ шарвагануулан эрхлэх Банхарыгаа харан баярласан тэр, “Должоон, сүү аваад ирээрэй”, гэж үүдэн дээрээсээ гэртээ сонсогдохоор хэлэхэд айдаст автан байсан хүүхдүүдийнх нь “Аав, аав, ааваа” гэж баярлан хашхиралдах чимээ, гэрийн хаалга онгойлгохтой зэрэгцэж нэг дор гурван хөөрхөн толгой цухайж, ард нь авааль эхнэр нь шанагатай сүү барин хоромхон зуурт айдас нь мишээлээр солигдох тэр л агшныг харуулан зогсоно. Сэтгэлд гал нэмсэн гайхамшигт энэ дүр зургаас хаанаас ч хайгаад оломгүй үнэтэй бүхэн гэрт нь л байгааг олж харсан Дандарын нүдэнд хайр гэрэлтэж, нүүрэнд нь баярын мишээл тодорлоо.





БҮЛЭГ

МОДДЫН ДУУ

...Сайн байна гэх шиг САЛХИ хүчтэйхэн үлээлээ.
Тэгтэл ой тэр чигээрээ “дуулан бүжиглэлээ”. Тэнд
ганцаараа сүглийх улиас ч хөгөө нэмж байх юм. Түүнийг
тойрсон нарс, хус, хуш модод ч баясан цэнгэлээ.
Түүрүүнээс хойш энэ сайхан “найрал дуу” л энэ ойд дутаад
байж. Хөг ая нь таарсан байна. Хөвч их ой дүүрэн боллоо.



ЭЭЖ НАР ХОЁР

*“...говийн агаарт нар, ус, элсээр өөрийгөө эмчлэх
байлаа...”*

Цолмон өглөө бүр ургах нарыг харж гараа дэлгэн наран “эхээсээ” адис авах дуртай. Үүнийгээ тэр өглөөний дасгал гэж нэрлэнэ. Хүн бүр нарыг шүтэн дээдэлдэг ч Цолмонгийн хувьд илүү утга учиртай билээ.

Их сургууль төгссөнийхөө дараа жилээс нэгэн байгууллагад ажиллах болсон ч удалгүй Цолмонгийн нуруу, бөөр хавиар нь маш ихээр өвддөг болов. Сүүлдээ ажлаа ч хийж чадахгүйд хүрэв. Ингээд эмнэлэг, эмч хэссэн хүн болж, үзүүлсэн хүн бүр ямар нэг онош хэлж, учрыг нь олохоо болин нэлээд хэдэн жил эмнэлэг эргүүлсэн боловч тусыг эс олжээ. Ийнхүү явахдаа эмнэлгийн гадаа ээжтэйгээ хоёулаа сууж байх зуураа нэгэн эмээтэй яриа өрнүүлцгээв. Яриан дундаа тэр эмээ “Хүү минь чи ямар өвчтэй юм бэ, харахад эрүүл саруул, сайхан царайтай юм, тэгтэл тэргэнцэртэй байх юм, яасан юм бэ охин минь” гэж асуужээ. Хариуд нь Цолмонгийн ээж охиныхоо өвчний байдал, түүний олон онош, эмчилгээ, хамгийн сүүлд нь үе мөчний архаг өвчин болоод удаан алхаж, зогсож чадахаа больсон учраас тэргэнцэр хэрэглэдэг болсон талаар товчхон ярьтал, эмгэн тэр хоёрт “Эмээ нь та нар шиг залуу байсан бол говийн агаарт нар, ус, элсээр өөрийгөө эмчлэх байлаа. Даанч хөгшин би хөдөө явах чадал алга болж дээ. Аян замын алжаал даахгүй биз” гэж ярьжээ. Энэ үгийг сонссон Цолмонгийн ээж “Нар, ус, элс гэнэ ээ” гэж олзуурхан дуу алдсан нь ээж, нар хоёртоо шүтсэн амьдралыг түүнд авчирсан юм.

Тэр зунаа ээж нь, эмнэлгийн гадаа уулзсан эмээгийн зөвлөгөөгөөр, Цолмонг нар, ус, элсээр эмчлэхээр хөдөө байдаг нагац эгчийндээ иржээ. Ирсэн өдрийнхөө маргаашаас эхлэн Цолмонгийн ээж өглөө бүр охинтойгоо хамт ургах нарыг угтан харж, түүний цацраг дагуулан дасгал хийлгэхээс тэдний өдөр тутмын эмчилгээ эхэлдэг болов. Дараа нь булгийн усыг аягалан уулгана. Ингээд их үдийн

дараах нарны цацрагийн хорт үе өнгөрсний дараа гэрийн ойролцоох элсэн толгойн нар ээсэн энгэрт хөл нүцгэн хэсэг алхана. Дараа нь ээж нь түүнийг эгчийнхээ өгсөн хонины шар тосоор бүх биеийг нь тослон хэвтүүлэхэд, наранд халсан элс дороос нь төөнөж, дээрээс нь нар эзвэрлэхэд өөрийн эрхгүй нүд нь анилдан хэсэгхэн унтана. Ийм байдлаар сар гаруй болоход Цолмон энэ бүх эмчилгээгээ хэн нэгний туслалцаагүйгээр өөрөө хийдэг болсон ба зуны гурван сарыг өнгөрөөгөөд буцах болоход түүний бие бүрэн эдгэрсэн байлаа.

Ийнхүү өөрийг нь хорвоод хүн болгон төрүүлсэн ээж, ивээлт цацрагаа тусган биеийг нь илааршуулсан наран эх хоёрынхоо тусламжтайгаар, өвчинд шаналан өөр зүйлийг бодож санахгүй байсан Цолмон ертөнцийг гэрэлт өнгөөр харах болжээ. Өвдөж өнгөрөөсөн мөч бүхнээ өөртөө эргүүлэн авч ирэх гэсэн мэт уйгагүй шаргуу байж, сувилагчийн сургууль дүүргэн, өөртэй нь адилхан өвдсөн, шаналсан хүмүүст туслахаар “Ээж нарны элч” нэртэй сувиллын газраа ээжтэйгээ хамтран нээж амжив. Удалгүй насны ханьтайгаа учирч, эрх бяцхан үрийнхээ зулайг ч үнэрлэв. Цолмон аз жаргалаар бялхсан энэ сайхан амьдралаа, “Ээж нар хоёроор цэцэглэсэн амьдрал минь” гэж үйлчлүүлэгчиддээ бахархан ярих ба анх түүнд зөвлөсөн эмээг бурхны элч байсан гэж талархан дурсах нь олонтаа сонсдоно.



ЦЭЦЭГС ХАЙРАНД ДЭЛБЭЭЛДЭГ



*...ганган цэцэгсүүд, сунгасан гар
шиг хадны нөмөрт хоргодон, хайр
юугаа шингээсэн усан дуслуудад
тэжээгдэн байгаа нь эгээ миний
амьдрал мэт ээ...*

Үргэлжилсэн их уулын чулуун хаднууд дунд гараа алдалсан хүн зогсох мэт тогтоцтой нэгэн хад эрдүүхэн дүнхийнэ. Түүний доор зүрхэн хэлбэртэй хэсэгхэн газарт уран байгалийн ургуулсан өнгө өнгийн цэцэгс үзэсгэлэнт төрхөөрөө гайхуулах мэт цомирлог юугаа дэлгэн, нарны буман цацрагт тэмүүлэн намилзах нь чухам л амирлангуй гоо ертөнцийн дагинас гэмээр. Ертөнцийн тэр гоо өнгөнд сэтгэл алдран шагширсан би “Яагаад энэ хэсэгхэн газарт ийм гоё цэцэгс өнгө алаглан ургадаг байна аа. Хааш хаашаа алдхан газар л ургасан байх юм” гэж ганцаараа ярьсаар дэргэд нь очвол хүний гар шиг урагш өнгийн тогтсон хаднаас усан дусал под под хийн дорх хадан дэвсэг дээрээ бууж, бяцхан урсгал болон зүрхэн тойрог дахь цэцэгсийг умдаалж байлаа. Энэхэн зүрхэн тойрогт үзэсгэлэнт цэцэгс өгсөх, хэвийх нарны цацрагийн зайгаар өнгө өнгөөр хувиран солонгорох нь “Одоо би ямар байна, одоо намайг хар даа” гэж аальгүйтэн инээмсэглэх шиг.

Цэцэгсийг харан алмайрч, ер бусын амирлангуйд зочлон зогссон би вээр өөрийгөө тэр ганган цэцэгстэй зүйрлэн баяслаа. Нүд булааж сэтгэл хөдөлгөсөн үзэсгэлэнт байгалийн үлэмжийн тансаг, ганган цэцэгсүүд сунгасан гар шиг хадны нөмөрт хоргодон, хайр юугаа шингээсэн усан дуслуудад тэжээгдэн байгаа нь эгээ л миний амьдрал мэт ээ. “Тийм ээ, хосын хорвоог уяраах хонгор үрсийнхээ

дуунд хамтдаа баясаж, зүүдээ аргамжин, зүрхээ жаргаахаар учирсан миний хань намайг тэжээх эрдэнэт рашаан, түших багана минь билээ” хэмээн бодох зуур ханьтайгаа учирсан цагаас хойших туулж өнгөрсөн үлгэрийн мэт гайхалтай сайхан амьдралын хором бүр өмнө минь өнгө будгаараа ялгаран харагдав. “Хайраа харамгүй асгасан түүний минь хайр нь хаднаас дуслах мөнгөн дусал юм. Тэр их хайрын асгамал бүсгүй заяаг минь бүрэн тэгшилж иржээ” гэсэн манант тэнгэр цэлмээм гэгээн бодол сэтгэлийг минь хөвөлзүүлэв.

Өнгө өнгийн цэцэгсийг харах тусам элдэв бодлууд эргэлдэн орооно. Байгаль өөрөө хүнийг бүтээж, нэгэн насны амьдралыг нь тэтгэдэг болохоороо хэлгүй ч гэсэн хүмүүн биднийг эрхшээж сүр хүчээрээ гайхуулан бишрүүлнэ. Хүн хэдий ухаантай ч байгалийн эрхшээлд захирагдахаас өөр аргагүй юм даа. Байгаль эх өөрөө үүнийг сонин содон дуу чимээ, яруу тансаг өнгө будаг, хатуу зөөлөн элдэв үзэгдлээрээ харуулах аж. Өнөөдөр ч үзэсгэлэнт цэцэгсийг ургуулсан байдал өмнө нь төрж байгаагүй бодлын эх байж, өмөг түшигт ханийн минь хэмжээлшгүй их хайрыг ямар ч ятгалагагүйгээр мэдрүүлснээрээ гайхамшигтай. Харин би гэдэг хүн хэдхэн цагийн амралтаараа хэмжээлшгүй жаргалаа олж харсандаа хорвоог бүхэлд тэвэрсэн мэт аз жаргалтай.



ХҮҮГИЙН ЗУРАГ

...үр минь чиний зурсан өнгө ертөнцийг бүтээдэг
ЮМ...

Ширээн дээр зурсан зургаа дэрлэн гартаа барьсан хөх харандаагаа ч тавилгүй ямар нэг сайхан зүүдний баясгаланг нүүрэндээ тодруулан хацраа хонхойлгон унтах бяцхан хүүгээ хараад өхөөрдөнхөн тэврэн авлаа. Хүүгийнхээ зурсан зургийг хараад “Эвий үр минь, энэ л хорвоод хүн болон мэндэлсэн Байгаль эхээ дүрслээ юу даа” хэмээн өөрийн эрхгүй бодлын мананд автав. “Учрыг нь л олох гэсэн юм” гэж элдэв зүйл хоргоон суудаг хүүгийн минь, зураг зурах ур нь гүйцээгүй ч ертөнцийг өөрийнхөө нүдээр зөв ажиглаж явааг мэдэрсэн эх би түмэнтээ баясаж, бодлын хэлхээг үргэлжлүүлэн хөвлөө.

Хүү минь, номин хөх тэнгэрийн доор ногоорон униартах тал нутгаа зуржээ. Цэцэг навч дэлгэрүүлжээ. Цэн тогорууг цэнгэг усанд нь хосоор нь эрхлүүлжээ. Талыг чимсэн таана мангирыг таньдаг болж миний хүү. Таван хэлээр шулганах шувуудыг бас ялгадаг болжээ үр минь. Тэртээ өндөрт дүүлэн нисэх шувуудын цувааг ч харж амжсан бололтой. Эргэлдэн нисэх эрвээхэй, энэ дэлхийн өдөр шөнийг ээлжлүүлсэн алтан нар, мөнгөн сараа ч бас зуржээ. Уулсыг ой хөвчтэй нь хөглийлгөн, голыг мяралзуулан, гоё ганган бүхнийг хослуулан таталжээ. Энгийн нүдээр харахад эрээн мяраан болгож энд тэндгүй сараачсан ч, өнгө будгийг нь хослуулж зурсан хүүгийнхээ зургийг ээж нь ингэж уншлаа. Эвий үр минь эрх хонгор чамд минь хэзээ, хэн үзэмжит байгалийн түмэн өнгийг зааж өгөө вэ гэмээр дүрсэлсэн байх юм. Аргагүй бид Байгаль эхийн үрс болохоор зөнгөөрөө бүхнийг мэдэрдэг бололтой.

Энэ зуур, бага байхдаа хөдөөгийн нэгэн сумын бригадын дэлгүүрийн гадаа могой гэдэг амьтныг анх харан айн зэвүүцсэн ч, барьж авахаар тонгойтол “хүүе, болохгүй, наадах чинь хатгана” гэж

хашгиран, хажуугаар өнгөрч байсан нэгэн эмэгтэй гараас минь угз татсаныг санах. Хэн нэгэн могойны талаар хэлж өгөөгүй ч тааралдах үед нь харахад нээрэн л аймаар сүрдмээр байж билээ. Хүү минь ч тийм л зөнгөөр бүхнийг ойлгож дээ гэж бодон, өдөржин сэтгэл тавгүйрхэн хийх байхаа олж ядан явсаар гэртээ ирсэн миний дотор цэлмэв. Хүү минь ертөнцийг олон өнгөөр харж байгааг ойлгон баясахын зэрэгцээ, бид амьдран байгаа нутаг орноо ийм сайхан онгон дагшнаар нь байлгах сан гэж санааширан бодлоо. Хүүгийнхээ, ухаарал хайрласан, зургийн дор он сар өдрийг нь тавилаа. Том болоод үзэг дээ миний хүү гэж бодон нэгэн шинэ хавтсыг нээн зургийг нь хавчуулав.

Тийм ээ, үр минь чиний зурсан өнгө ертөнцийг бүтээдэг юм. Үргэлж гэгээлэг энэ өнгөөр бүхнийг харж чадсан шигээ эргэн тойрноо, эгэл олноо харж яваарай үр минь гэж тайван нойрсох хүүдээ шивнэлээ.



АЛТНЫ СУДАЛ

“...би чинь эх хүн, байгалиа сүйтгэлцэж болохгүй шүү дээ” гэж гэмшингүй бодоод машин руугаа хурдан хурдан алхлав...

Гэр дотор гадаа ажиллах моторын пад пад хийх дуу хааяа нэг өндөр болон, хааяа нэг сул болон сонсогдоно. Сүрэн өчигдрийн угаасан алтаа гаргаж их л сэтгэл ханамжтайгаар амандаа дуу аялан босч авдарныхаа цоожийг онгойлгон ёндой хэмээх савандаа жинлэсэн алтаа нэмж хийв. “Дүүрэх дөхөж байна шүү, аз байвал өнөөдрийн ажлаар дүүрээд, үгүй бүр даваад асгах ч юм бил үү. Тэгвэл ч мөн тэнгэрийн элчийг тэргүүндээ заллаа л гэсэн үг” гэж шуналтан бодов. Сүрэн өөрийнхөө сайхан бодолд баясан нүд нь гялалзаж, хөл нь хөнгөрөн, бие нь туялзан гунхалзаж бүсгүй хүн аз жаргалтай болохоороо гаргадаг бүхий л сэтгэл хөдлөлүүдийг гарган байлаа.

Моторын дуу гэнэт унтрахад Сүрэн хурдхан гарч очвол “Мотор эвдэрчих шиг боллоо” гээд чулуучин залуус нь тал талаас нь юу нь болохоо байсныг мэдэхээр өнгийцгөөж байв.

Сүрэн түрүүхэн бодсон бодол нь талаар болох вий гэж сандран бодож,

- Юу нь эвдэрсэн юм бол сэлбэг нь байгаа болов уу, хэр хурдан засах бол гэж давчдан асуув. Түүний асуултад чулуучдын ахлагч,

- Пооршин нь хагарсан байна. Сэлбэг байхгүй тул төв рүү хурдан шиг захиж авчрах хэрэгтэй гэв. Нэгэнт ийм болсон хойно өөртөө ашигтайгаар ажлаа хэрхэн зохицуулахаа Сүрэн мартсангүй, алт угаагчийн моторын сэлбэгийг олж, засагдах хооронд ахиухан чулуу бэлдээд авах юм шүү гэж бодож амжив. Тэдний жижигхэн кэмп чулууны газраас холгүйхэн. Алтны чулууг тэслэх дуу өдөр шөнө хэзээд ч байсан сонсогдоно. Түүнийг сонсож байгаад нэг тэсэлгээний дараа очиход нэлээд их чулуу авч болдог бөгөөд энэ удаад ч хуучин

аргаа хэрэглэхээр шуудай саваа бэлтгэн базаав. Удсангүй нэлээд том тэсэлгээний нүргэлсэн их чимээ гарав. Чулуугаа бэлтгэн татаж авах ажилд Сүрэн нэг ч удаа явж үзээгүй бөгөөд энэ удаад чулуучдын ахлагч сэлбэг авахаар аймгийн төв явсан тул өөрөө үлдсэн залуусаа дагуулан явахаас өөр арга байсангүй.

Наадам болж байна уу гэхээр олон машин цугларсан газар байв. Түүнийг харсан залуус нь,

- Пөөх, улам л олон хүн нэмэгдээд байх юм даа гэж ам амандаа хэлцгээж байв.

Сүрэн машинаас түрүүлэн буугаад чулуун хадны зах бараадан алхав. Хөл дор тэсэлгээнд суларсан чулуунууд тээглэж, явахад төвөгтэй байсан ч хад руу зүтгэсээр дэргэд нь хүрэв. Тэгээд гараа хүргэтэл ус гарах шиг болов. Хаанаас ус гарав хэмээн бодоод лавшруулан харвал, саяхан тэсэлгээнд орсон болохоор судлууд нь тодоос тод харагдах газрын завсраас нарийхан ус урсан гарч ирэхийг хараад алт авах гэж улайран уулыг тэсэлсэн хүмүүст чулуун хад гомдон уйлж байх шиг санагдав. Үүнийг харсан Сүрэн “чулуу ч гэсэн өвдөхийг мэдэж байгаа даа” гэсэн бодол төрөхөд сэтгэл нь тавгүйтэж, гунигт автан “би чинь эх хүн, байгалиа сүйтгэлцэж болохгүй шүү дээ” гэж гэмшингүй бодоод машин руугаа хурдан хурдан алхлав. Эргэн алхав. Машинадаа суунгаа,

- Буцъя гэж эрсхэн хэлэхийг нь сонссон залуус өөд өөдөөсөө гайхан харсан ч

- Яагаад буцах болов гэж хэн ч асууж зүрхлэсэнгүй. Учир нь тэд Сүрэнгийн эрс шулуун занг мэддэг билээ.

Буцаж ирээд гэр рүүгээ буцах бэлтгэл хийж дуусаад залуусаа дуудан, - Энэ та нарын хөдөлмөрийн хөлс. Тиймээс үүнийг та нарт бүгдийг нь өгч байна. Та нар тэнцүү хуваагаад аваарай гэж шулуухан хэлчихээд, ёндойтой алтаа ширээн дээр бүгдийг нь орхин аймгийн төв явахаар гарч одлоо.



ЦАГААН ТЭМЭЭ

...“Зулзагаа тээсэн цагаан тэмээ таарвал дээрээс
нь ус хийхлээр тал тал тийшээ бутран алга
болдог...”


Холдоорой холдоорой гэцгээн голын ширгэн дээр ямар нэг зүйлийг сонирхон тойроглон тонгойсон хүүхдүүд арагшаа ухарцгаах нь бүжиглэх мэт харагдав. Тэдний дотроос нэг нь “Болохгүй шүү дээ, цагаан тэмээг оролдож болдоггүй юм гэж манай ажаа хэлдэг байхгүй юу” гэх сонсогдов.

Цагаан тэмээ гэхийг сонсмогц хамаг бие арзаганан жихүүцэж, түүнийг оролдох вий хэмээн сандарч хүүхдүүдийг болиулахаар тэдэн рүү яарав. Тэгтэл хүүхдүүд хашгиралдан тарж гүйв. “Юу болов” гээд дөхөн очтол хөршийн хүү Батаа “энэ... шанагаар ус хийчихсэн” гээд айсан, сандарсан бас миний зөв шүү гэсэн янзтай, хоосон шанагаа савчуулан, дотогшоо гишгэсэн хоёр хөлөө гадагш нь майжигануулан гэмшингүй зогсож байлаа. Дэргэд нь байсан хүүхдүүд ч том хүн хараад эмээнгүй байцгаагаасан ч илт тайвширсан бололтой. Цагаан тэмээн дээр ус асгаж зовлонт эхийг үүрч яваа “лай”-наас нь үүрд салгасан хэмээн өөрсдийгөө магтан зэрэг зэрэг шулганалдаж эхлэв. Усанд норсон цагаан тэмээг “аль байна” хэмээн асууж, заалгаад тонгойн харвал нээрэн л амарсан шиг харагдав. Тэгээд “Цагаан тэмээ айхаараа өөрийгөө хамгаалж хортой шүлсээрээ хатгадаг аюултай. Та нарыг хатгуулчих вий гэж айлаа. Ашгүй та нар зүгээр шив ” гэж баярласнаа нуулгүй хэлэв.

Цагаан тэмээ гэх энэ амьтныг, зулзаганууд нь эхийнхээ нуруун дээр өсөхдөө чадалгүй нэгнээ барьж идсээр эцэст нь эхийгээ иддэг гэдгээр нь хүн бүр жихүүцэн зэвүүрхэж, хорвоогийн хамгийн муухай амьтан гэлцдэг билээ. Би ч хүмүүстэй адил бодолтой ба тааралдахгүйг хичээж, харагдвал холуур тойрон өнгөрдөг байв. Гэнэт бодлын мэлмийд гэгээ татаж “Тэрхүү зулзагануудын эх нь байгаль эх

дэлхийтэй минь адил юм даа. Тэгээд хүмүүн бид байгалийн хишгээр амьдарч байгаа шиг зулзаганууд нь эхийнхээ шимийг хүртэж амьдарч байдаг юм болов уу даа” гэсэн бодол төрж, зулзагуудыг “уучлав”. “Зулзагаа тээсэн цагаан тэмээ таарвал дээрээс нь ус хийхлээр тал тал тийшээ бутран алга болдог. Тэгэхээр тэр эх амардаг гэж нутгийн хүмүүс ам дамжин ярьдаг” “Тэгвэл эх дэлхий, эх байгаль маань үр хүүхэд болсон хүмүүн төрөлхтөнд ямар их “өвдөлтийг” тэсвэрлэн юу байгаагаа харамгүй өгч байдаг юм бэ?” гэж бодох зуур эх дэлхийгээс хүртдэг бүхэн нүдэнд харагдах шиг болов. Тийм ээ, бидний амьдрал эх дэлхийгээсээ байгалаасаа л эхтэй. Бид л хайрлах ёстой. Ийнхүү бодсоор яваад гэрийнхээ үүдэнд ирлээ.

Гэрт нөхөр маань тамхины утаа баагиулсаар, сураа элдэж суулаа. Саяын болж өнгөрсөн зүйлийг өөрийнхөө бодолтой нэгд нэгэнгүй ярьснаа “Үгүй ээ хө, хүн болгон л байгалиа хамгаалахад оролцоно, булаг шанд хамгаална, мод тарина гээд байхад хоёул хоцроод яах вэ? Сумаас мод тарих газар авч чадах хэмжээгээрээ мод тарихад оролцсон нь дээр байх аа?” гэж асуух, шийдвэрлэх зэрэгцүүлэн хэлтэл түрүүнээс хойш утаа үлээн чимээгүй суусан тэр минь “Тэр ч харин хүн болж төрснийх хийх ёстой ажил шүү” гэсээр элдэж байсан сураа ханын толгойд өлгөөд шон дээрх хоёр морио тавихаар чөдөрнүүдээ аван гарав.



УХААНААР УХАГДСАН УУРХАЙ

“...Эдэнгүйгээр хармаг ургадаггүй, өнөөх байгалийн тэнцвэр гэдэг чинь л энэ байгаа юм”...

Олон жил уулзаагүй найзтайгаа гудамжинд гэнэт тааралдав.

- Сайн байна уу?
- Ямар сонин хүн бэ? гэцгээн бид тэврэлдэн уулзалдав.

Уулзаагүй хориод жил болсон бид, тухтайхан ярилцахыг хэн хэн нь хүсч байснаас нэгэн кафед орж түр атугай тухлахаар болов. Найз маань наймдугаар ангид байхад шилжин явсан ба тэр үедээ захиагаар харилцаж байснаа сүүлдээ чимээ тасарсан билээ. Найз Цэрмаагийн минь инээмсэглэн суух нь яг л багын төрхөөрөө аж. Хэн нь юу хийдэг, ямар амьдралтай байгаа талаараа, гэр бүлийнхнийхээ тухай асуух, ярих зүйл үе тэнгийн найзууд бидэнд их байлаа.

- За найз минь ямар хүнтэй гэрлэсэн бэ? Хэдэн хүүхэдтэй юэ? Юу хийж байна? гэж миний сонирхон асуусан асуултад

- Өө найз нь Балт гэдэг хөдөөний малчин залуутай гэрлээд, хүү охин хоёртой болсон. Ер нь мал маллаж байгаа. Хажуугаар нь сонирхолоороо гэдэг юм уу, боломжоороо гэдэг юм уу үйлдвэрлэл явуулж байгаа гэж даруухан гээч нь хэлээд,

- Харин чи гэж миний асуусан асуултыг эргүүлэн асуув. Би ч өөрийнхөө тухай хариу мэдээлэл өглөө. Цэрмаа,

- Өглөө хөдөөнөөс ирсэн, ажил ихтэй зав муу болохоор би бараг төв рүү орж ирдэггүй. Миний хань л хол ойрын ажлуудыг амжуулдаг юм. Багын найзтайгаа уулзах ямар сайхан юм бэ? Ер нь чи гэр бүлээрээ манай хөдөө зочилж очвол яасан юм вэ? Тэнд тухтай уулзаж ярих, үзүүлэх зүйл их байна, гэв. Би ч

- Тэгэлгүй яах вэ, очъё. Харин хэзээ та нар хүлээн авах боломжтой вэ гэж хариу асуухад

- Бид өнөөдөр буцна. Энэ сардаа бол хэзээ ч байсан хүлээн авахад бэлэн гэж ажлаа сайтар төлөвлөж сурсан хүний шинжтэй хэллээ. Ингээд Балтынд зочлохоор тохиролцон, бидний уулзалт өндөрлөв.

Орой нь гэртээ ирэн багын найзтайгаа уулзаж, тэднийд гэр бүлээрээ зочлох урилга авсан тухайгаа хэлээд, энэ удаагийн амралтаараа Балтынд очих болов.

Бидний замд элсэрхэг тал үргэлжлэх бөгөөд замын урд талд нэг хэсэг газар ногоорон харагдаж, ойртох тусам хашаа, ус, байшин нь тодрон харагдав. Их үдийн наран шаргал талыг манхайлгах үеэр хашааны үүдэнд ирэхэд “Далай булаг” үйлдвэр гэсэн тод хаяг нүдэнд тусав.

Биднийг Балтынхан баяр хөөртэй угтлаа. Хашаан дотор байгалийн чулууг өнгө алаглуулан үелэн хээлж явган зам засчээ. Түүний хоёр талаар хармагийн том том бутнуудад эрхий хуруун чинээ хармаг жимс ургасан нь ногоон торгон дээрх улаан цэцгэн хээ мэт. Ай юутай үзэсгэлэн. Энд тэндээс могой гүрвэлүүд ойр ойрхон гүрвэлзэн давхилдаж, үе үе хэрэгт дурлан өндийн харна. “Ямар их могойн гүрвэлтэй юм бэ” гэж сонирхон асуувал, Цэрмаа “Эд чинь хармагийг маань эрхий хуруун чинээ болтол нь ургуулдаг юм шүү дээ. Эдэнгүйгээр хармаг ургадаггүй, өнөөх байгалийн тэнцвэр гэдэг чинь л энэ байгаа юм” гэж хариу тайлбарлахдаа тэдэнд хэчнээн хайртай нь харагдаж байлаа.

Балтынх таван жилийн өмнө хэдэн жил хураасан малынхаа ашиг шимээр зуу гаруй га газрыг Далай булагтай нь хамт хамгаалалтад авсан аж. Сумын төвийн хогонд дарагдан байсан Далай булгийн усыг нутгийн чулуугаар хашсан цөөрөмд хуримтлуулжээ. Ингэж хармагийн бутгаа говийн татуу борооны эрхшээлгүйгээр услах болсон байна. Энэ их ажлыг Балтын гэр бүлийн дөрөвхөн хүн хийсэн гэж бодохоор бишрэн бахархах сэтгэл төрнө.

Хармагийн дарс шимэн тэр оройжин хорвоогийн сонин хачин олон сайхан зүйлсийг ярьсны ихэнх нь тэдний босгосон ид шидэт

үлгэрийн гэмээр амьдрал байлаа. Яриан дундаа Цэрмаагийн “Хармаг жимсэнд залуу насыг чигээр нь хадгалах увидас байдаг. Манай дарсыг гадаадын хоёр ч компани худалдан авахаар гэрээлээд байгаа” гэж ярихыг нь сонсоод, “Цэрмаагийн нүүр царай үрчлээгүй толигор, багынхаа янзаар байсан нууц энэ байжээ. Уурхайгаа биш, ухаанаа ухаж амьдаръя гэж нэгэн ахмад малчны хэлж байсан үг энэ л байна шүү дээ” гэж найзынхаа гэр бүлийн бүтээсэн гэгээн их үйлсээр бахархаж бодлоо.



МОДДЫН ДУУ

...Өтгөн их шугуйн нэг нэг халуун амь...

Ойн их төглийн захад ихэмсэгээр дүнхийх өтгөн хар улиас, түүнийг тойрон үргэлжлэх нарс, хус, хушийг харан зогсоход байгаль эх бидэнд чимээгүйхнээр олон зүйл ухааруулдгийн нэгийг мэдрэв. Тэр улиас олон салаа мөчиртэй, мөчир бүр нь навчсаар дүүрэн, түүндээ нэг л эрдэнгүй мэт байх агаад, цаанаа л сүртэй, бас гунигтай. Түүнийг тойрсон нарс, хус, хуш модод бяцхан бөгөөд дэргэдээ байгаа улиасанд бүхий л сүр сүлдээ өгчихсөн мэт шингэн, хөнгөн харагдах ч нэн үзэсгэлэнтэй. Он цагийн үргэлжилсэн хэлхээсэнд олон хаварт навчсаа нахиалуулан дэлгэрүүлж, олон намарт навчсаа хөврүүлэн газарт дэвссэн модод орчлон хорвоог чимсээр л. Тэдний одоох байдал орчлонгийн тоосонд бүдгэрнэ гэж үгүй.

Харин надад улиасыг харан, түүнийг өрөвдөх сэтгэл өөрийн эрхгүй төрөв. Өөрөө тэр дүнхийн сүглийж, бүхнээс өндөр, өтгөн гэж гайхуулан найгах ч өөрийнх нь үзэсгэлэнг тойрсон олон жижиг мод тэртээ дороос харахгүй байгааг яахан мэдэх билээ. Улиасыг тойрсон моднууд хоорондоо эн чацуу болохоороо их нууцыг дундаа хийж, сарчигналдан шуугих намираандаа замхруулах мэт.

Өндөр модны дор очин зогсож үзлээ. Өндөр юм аа. Өтгөн юм аа. Бас гайхалтай үзэсгэлэнтэй юм. Даанч гар минь ганц навчинд нь ч хүрсэнгүй. Ийнхүү зогсохдоо хүмүүний амьдралын богинохон хугацаанд өтгөн, өндөр улиас биш, тойрсон, тойруулсан нарс, хус, хушны нэг байхыг хүслээ. Тэд нэг л өдөр бүгд өндөр, өтгөн моднууд болно. Өтгөн их шугуйн нэг нэг халуун амь байна. Тэр цагт тэдний нэг байхыг хүслээ. Өндөр мод байх амархан санагдав. Өөрөө би энэ улиас шиг ихэмсэг, эрхэмсэг байж чадахаа л харин төсөөлсөнгүй. Яруухан, даруухан нарс, хус, хушны нэг байхаараа яах бол?, гэж бодов. Согтуу

шуурга шургалан орох зайгүй ургасан “бидний” найган ганхах нь өндөр модны сэрчигнэх төдийн салхинд хөдлөхөөс цөөхөн баймаар, солонго халхалсан нарны туяанд өнгө өнгөөр гялалзмаар, анир алдах харанхуйд хамтдаа баймаар олон сайхан мэдрэмжүүд төрлөө.

Өглөөхөн оргилд ганцаараа гарахаар тэмүүлж байснаа ухаарлаа. Өнөөдөр энд ганцаараа ирсэндээ ч ичлээ. Өндөр өтгөн ганц улиас нөмөргүй санагдлаа. Өнгийн цааш хараад өрөөл сэтгэл хоосон болохыг мэдэрлээ. Өргөн түмэнгүйгээр хэн ч биш гэдгээ ч ойлголоо. Миний ухаарахтай зэрэгцэн салхи намуухнаар үлээж эхлэв. Сайн байна гэх шиг хүчтэйхэн үлээлээ. Тэгтэл ой тэр чигээрээ “дуулан бүжиглэлээ”. Тэнд ганцаараа сүглийх улиас ч хөгөө нэмж байх юм. Түүнийг тойрсон нарс, хус, хуш модод ч баясан цэнгэлээ. Түрүүнээс хойш энэ сайхан “найрал дуу” л энэ ойд дутаад байж. Хөг ая нь таарсан байна. Хөвч их ой дүүрэн боллоо.

Буцах цаг болжээ, баяртай их ой минь, та нарынхаа өгсөн ухаарлаар түмэн олонтойгоо төгөлдөр сайхан амьдрах болно. Эрч өгсөн модод минь, эргээд би олонтойгоо ирнэ. Эгэл олон та нараар минь бахархах болно. Эрин зуун өнгөрсөн ч энэ хэвээрээ байгаарай эх байгалийн нандин үрс минь.



Нэр томъёоны тайлбар

1. Таана- Бэлчээрийн ургамал бөгөөд хvнсэнд ашиглаж болно.
2. Ороомог-тааныг бүхлээр нь цувьж бүдүүн болгож ороох бөгөөд голдоо чийгтэй хатдаг учир шимт тэжээл болдог
3. Зоодой –тааныг гараар, машинаар татан хэрчиж, жижиг саванд хэвлэн хатааж хийсэн малын тэжээл
4. Огодой-үхэр огодой: говь хээрт амьдардаг мэрэгч амьтан
5. Мамбаса- үрлэн хатуу чихэр
6. Пионер уул- Өмнөговь аймгийн Ноён сумын төвийн баруун хойд талд орших уулыг нутгийн хүмүүс ийнхүү нэрлэдэг.
7. Хонины морь- хонь хариулахдаа унадаг хамгийн номхон морь
8. Бал алаг –морины зүс /сааралдуу өнгө орсон алаг зүсмийн морь/
9. Сондуул-говийн хужирлаг хөрсөнд ургадаг жимст бут
10. Өвөөлж- *Uripidae* овгийн толгойн орой дээрх титэм мэт залаагаар онцлог, Африк ба Евразид тархан нутагладаг эрээн өнгөт шувуу.
11. Зунжаа-зуслан
12. Зэрэглээ-шатам халуун говь цөлийн захгүй талд гэрлийн хугарлаар үүсч, ус мэт харагдах байгалийн үзэсгэлэнт “хий үзэгдэл”
13. Татаалын ус - хулангийн татаал, хулан усны үнэрээр цомбон туурайгаараа газар цавчин хонхойлоход ундарсан цэнгэг ус
14. Түйрэн-нанги тоос, маш нарийн ширхэгтэй нунтаг шороо
15. Цагаан тэмээ-хортой аалз, цагаан өнгийн тэмээн аалз
16. Хармаг – сондуулд ургадаг говийн жимс. Долоон сард боловсорч гүйцдэг.



Бүдээгийн БАЯРЧИМЭГ

Өмнөговийн сургамжит
өгүүллэгүүд буюу “Амин хэлхээ”
номын зохиогч.

2013 оноос эхлэн байгаль
орчныг хамгаалах сэдвээр
нийтлэл өгүүлэл бичиж, “Алтан
нутгийн мэдээ” сонинд нийтэлж
байсан.

“Галтууд” ХХК –ийн Гүйцэтгэх
захирал, “Ухаалаг шийдэл -
Гэгээн амьдрал”
Эмэгтэйчүүдийн ТББ-ын
Гүйцэтгэх захирал.

Боловсрол:

МУИС-ийг Эдийн засагч -
Статистикч мэргэжлээр төгссөн.
Бизнесийн удирдлагын магистр.

Бизнес эрхэлж буй салбар:

Барилга угсралт, барилгын
материал үйлдвэрлэл, авто
зам, тээвэр, оёдол

Хэлэх дуртай үг: Хайр,
хүндлэл бол сайхан бүхний
эхлэл

Хобби: Ном унших, шинийг
санаачлах